



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн”

Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих
дотоод хяналт сайжирснаар зөрчил буурсан байна.

Аудитын код: ГАГ-2019/09/-ГА

Цахим хуудас:
www.audit.mn
Дорноговь аймаг
2019 оны 11 сар

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
Ахлах аудитор: Э.Энхцэцэг
Утас: 70523020 Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn
Аудитор: Б.Уранбилэг
Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn
Гэрээт ажилтан: Д.Дэлгэрзул

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	4
Хүснэгтийн товъёог	5
Дүрслэлийн товъёог	6
Хавсралтын товъёог.....	7
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	7-8

БҮЛЭГ 1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ САЙЖИРСАН Ч ЗАРИМ АЖИЛТНУУДЫН АЖЛЫН ХАРИУЦЛАГАТАЙ ХОЛБООТОЙ АЛДАА ГАРЧ БАЙНА.

1.1 Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа ч холбогдох хяналтыг сайжруулах шаардлагатай байна.	9
1.1.1 Сангийн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөлтийг холбогдох тооцоо, судалгаанд үндэслэн боловсруулжээ. /1.1.2/	10-11
1.1.2 Орлогыг бодитой тооцож хуваарилаагүйгээс сан хооронд шилжүүлэн зарцуулсан байна. /1.1.3/	12-16
1.1.5 Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй байна.	17
1.1.6 Сангийн хөрөнгийн зарцуулалтад дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлж байгаа ч зөрчил байсаар байна.	18-19
1.2. Иргэдэд эрүүл мэндийн даатгалын сангаас үзүүлэх тусламж үйлчилгээний талаарх мэдээллийг сурталчлан таниулах байдал хангалтгүй байна.	
1.2.1 Сангийн хөрөнгийн зарцуулалтын төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна. /1.2.3/	20
1.2.3. Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байна. /1.2.4/	20-21
1.2.4 Хөнгөлөгдөж байгаа эмийн тоо, хөнгөлөх хувь хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой эмийн сангуудад олгох санхүүжилтийн батлагдсан төсөв хүрэлцдэггүй байна /1.2.5/	22-23
1.2.5 Байгууллагын бүтцэд өөрчлөлт орохоос өмнө дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлээгүй байна. /1.2.6/	24-24
1.3 ҮОМШӨ-ний даатгалын сан, ажилгүйдлийн даатгалын санд хяналтыг тогтмол хэрэгжүүлж байгаа хэдий ч алдаа зөрчил давтагдсаар байна.	
1.3.1 Сангийн төсвийг өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслэлгүй төлөвлөж байна.....	25
1.3.2 Холбогдох хууль тогтоомжийн зарим заалтыг зөрчиж тэтгэвэр, тэтгэмж олгосон байна.	26-29
1.3.3 Дотоод хяналтын тогтолцоо сайжирч, хяналтын үр нөлөө дээшилж байна.....	30

1.5 Сангуудын авлагыг барагдуулах тодорхой арга хэмжээ авч ажилласан ч хуримтлагдсан авлагын дүн буураагүй байна.

1.5.1 Уул уурхайн компаниудын тогтмол бус үйл ажиллагаанаас шалтгаалж найдваргүй авлага үүссэн байна.31

1.5.2 Авлагын насжилтад тохируулж тодорхой арга хэмжээ авч ажилласан байна. ...32

БҮЛЭГ 2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

2.1 НДЕГ-аас ажиллагсдын нийгмийн хамгааллын зардалд 39.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

2.1.1 Холбогдох журамд заасан шалгуур хангасан ажилтнуудад дэмжлэг үзүүлсэн байна.32

2.2 Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг үндэслэн ТАХ хэрэгжүүлсэн байна.

2.2.1 ТАХ-г хэрэгжүүлэх шаардлагыг тодорхой хүргүүлсэн байна.33

2.2.2 Барилгын ажлын техникийн нөхцөл болон бусад холбогдох зөвшөөрлийг дахин авах шаардлага үүсээгүй байна.33

2.2.3 ТЭЗҮ хийгдсэн, зураг төсөв батлуулсан ТАХ-г хэрэгжүүлсэн байна.33

2.2.4 ТАХ-ний зураг, төсөвт өөрчлөлт ороогүй байна.34

2.2.5 Хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж ТАХ-г хэрэгжүүлсэн байна.34

2.3 Худалдан авах ажиллагаанд баримтлах хуулийн зарим заалтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

2.3.1 Үнэлгээний хороог худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшээгүй ажилчдаар бүрдүүлсэн байна.34

2.3.2 Тендерийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу боловсруулсан байна.34

2.3.3 Тендерт оролцогчийг өрсөлдөх боломжоор хангасан байна.35

2.3.4 Хууль тогтоомжид заасны дагуу худалдан авах ажиллагааны журмыг сонгосон байна.35

2.3.5 Тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн ч худалдан авах ажиллагааны баримтын бүрдэл хангалтгүй байна.35

2.4 ТАХ-г гэрээнд заасны дагуу гүйцэтгэсэн байна.

2.4.1 Гүйцэтгэгч байгууллага ажил гүйцэтгэх гэрээнд заасан хугацааг баримтлан ажлыг бүрэн гүйцэтгэсэн байна.36

2.4.2 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.36

2.4.3 ТАХ-ний санхүүжилтийг гэрээнд заасан нөхцлийг үндэслэн шилжүүлсэн байна.	37
2.4.4 Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.	37
2.5. Урсгал болон хөрөнгийн зардалд тавих хөндлөнгийн болон дотоод хяналтаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.	38
Холбогдох байгууллагын санал	40-41
ДҮГНЭЛТ:.....	42
ЗӨВЛӨМЖ:	43

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУ	Монгол Улс
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
НХХС	Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайд
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДС	Нийгмийн даатгалын сан
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НДТ	Нийгмийн даатгалын тасаг
НД	Нийгмийн даатгал
ХЧТА	Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж
ЖАТ	Жирэмсэн, амаржсаны тэтгэмж
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал компани
СС	Сангийн сайд
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТАХ	Төсөл арга хэмжээ
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
АТ	Ажилгүйдлийн тэтгэмж
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
АДС	Ажилгүйдлийн даатгалын сан
УИХ	Улсын их хурал
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДСЗ	Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөл
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМДТ	Эрүүл мэндийн даатгалын тасаг
ЭМДШ	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Хүснэгтийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Нийгмийн даатгалын сангийн төсөв, гүйцэтгэл	
Хүснэгт 2	Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангийн төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл	
Хүснэгт 3	Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангийн зарцуулалт	
Хүснэгт 4	Нөхөн даатгалд хамрагдсан иргэдийн судалгаа	
Хүснэгт 5	Тэтгэмжийн зардлыг байгууллагын өглөгт тооцсон судалгаа	
Хүснэгт 6	ЭМДС-аас гэрээт эмийн сангуудад олгосон санхүүжилтийн батлагдсан төсөв, гүйцэтгэл	
Хүснэгт 7	ЭМДС-аас гэрээт эмийн сангийн гэрээ дүгнэсэн үнэлгээ, санхүүжилтийн хуваарилалт	
Хүснэгт 8	ҮОМШӨДС-ийн шимтгэл төлөлт	
Хүснэгт 9	Рашаан сувиллын үйлчилгээний зардал олголтын судалгаа	
Хүснэгт 10	Авлагын насжилтын судалгаа	

Дүрслэлийн товъёог 1

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч иргэдийн мэдээлэл	
Дүрслэл 2	Тэтгэвэр тэтгэмжид хамрагдсан иргэдийн мэдээлэл	
Дүрслэл 3	Тэтгэврийн төрөл, тоо	
Дүрслэл 4	Тэтгэмжийн даатгалын сангийн зарцуулалт	
Дүрслэл 5	ЭМДС-ийн шимтгэл төлөгч	
Дүрслэл 6	ҮОМШӨДС-ийн төсөв, гүйцэтгэл	
Дүрслэл 7	АДС-ийн төрөл	
Дүрслэл 8	ҮОМШӨДС-д иргэдийн хамрагдалтын байдал	

Дүрслэлийн товъёог 2

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Тэтгэвэр тэтгэмжид хамрагдсан иргэдийн тоо	
График 2	Улсын төсвөөс олгосон санхүүжилт	
График 3	ЭМДС-ийн зардлын төсөв, гүйцэтгэл	
График 4	Ажилгүйдлийн тэтгэмж авсан иргэдийн судалгаа	
График 5	НДШ-ийн авлагын судалгаа	
График 6	Авлагын судалгаа /байгууллагаар/	

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудас ны дугаар
Хавсралт 1	НДШ-ийн авлагын насжилтын судалгаа	
Хавсралт 2	НД-ын авлагын судалгаа /байгууллагын төрлөөр/	
Хавсралт 3	НДШ-ийн өглөгтэй аж ахуйн нэгжийн судалгаа	
Хавсралт 4	НДЕГ-аас 2012-2018 онуудад ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр олгосон санхүүжилтийн судалгаа	
Хавсралт 5	НДЕГ-аас 2012-2018 онуудад ажилтнуудад олгосон шагнал, урамшууллын судалгаа	
Хавсралт 6	НДЕГ-аас 2012-2018 онуудад ажилтнуудад олгосон нөхөн олговрын судалгаа	

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2019 оны 04 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын "Аудитын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" 2019 оны А/45 дугаар тушаалын дагуу "Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн"-д Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэнэ.
Аудитын зорилт	Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.
	Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: - Сангуудын тогтолцоо, хөрөнгийн зарцуулалт үр нөлөөтэй байгаа эсэх; - Нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлсэн хөрөнгийн болон нийгмийн хамгааллын зардлын зарцуулалт үр дүнтэй байгаа эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл, орон нутаг дахь нийгмийн даатгалын байгууллагууд, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл, орон нутаг дахь Эрүүл мэндийн даатгалын байгууллагууд, Гомдол шаардлагын зөвлөлийн 2012-2018 оны үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон ажилтнуудын нийгмийн асуудал шийдвэрлэсэн байдал, тэтгэмж тусламж олголт, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материал, статистик судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Ариунаа удирдаж, ахлах аудитор Э.Энхцэцэг, аудитор Б.Уранбилэг, гэрээт ажилтан Д.Дэлгэрзул нар гүйцэтгэв.

Аудитын тайлан, судалгааг 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор нэгтгэн, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар баталгаажуулж, дарга, тэргүүлэх аудиторовн 2019 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/29 тушаалаар баталгаажуулж, 2019 оны 11 сарын 18-ны дотор Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

**Хүндрэл
бэрхшээл**

- Аудитаар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Сайншанд сумын ЗДТГ-аас нас барсан иргэдийн мэдээллийг алдаатай гаргаж ирүүлснээс нийгмийн даатгалын сангийн мэдээлэлтэй тулгахад цаг хугацаа алдах, илэрсэн зөрчлийг дахин нягтлах нөхцөл үүссэн.
- Аудитыг гүйцэтгэх хугацаа бага, хамрах хүрээ их, хүний нөөцийн дутагдалтай байдал зэргээс шалтгаалж аудитын чанарт нөлөөлөх эрсдэлтэй байлаа.

БҮЛЭГ 1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ САЙЖИРСАН Ч ЗАРИМ АЖИЛТНУУДЫН АЖЛЫН ХАРИУЦЛАГАТАЙ ХОЛБООТОЙ АЛДАА ГАРЧ БАЙНА.

1.1 Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа ч холбогдох хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Ерөнхий мэдээлэл:

Монгол Улсын Нийгмийн даатгалын сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлд дараах эх үүсвэрээс сангийн орлогыг бүрдүүлнэ гэж заасан байна. Үүнд:

- Даатгуулагчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл
- Ажил олгогчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл
- Сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү, үнэт цаасны арилжаанаас олсон орлого
- Улсын төсвөөс олгох хөрөнгө
- Бусад эх үүсвэр

2012-2018 онуудын аймгийн Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлогыг авч үзэхэд ҮОМШӨ-ний даатгалын сангаас бусад сангуудын орлого 16-56 хувиар давсан үзүүлэлттэй байна. /Хүснэгт №1/.

2012-2018 оны нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /өссөн дүнгээр/

Хүснэгт №1

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН	ТӨРӨЛ	Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Биелэлт
	Тэтгэврийн даатгалын сан	104333.5	163090.2	156%
	Тэтгэмжийн даатгалын сан	11436.8	13895.6	151%
	ҮОМШӨ-ний даатгалын сан	13543.6	12177.0	89%
	ЭМДС	30620.7	35657.0	116%
	Ажилгүйдлийн даатгалын сан	3850.2	4827.3	125%

Дээрх судалгаанаас харахад тэтгэврийн даатгалын сангийн орлогын гүйцэтгэл нь бусад сангийн гүйцэтгэлээс илүү байгаа нь тэтгэврийн нөхөн даатгалын шимтгэлийн орлого 2013-2018 онуудад нэмэгдсэнтэй холбоотой байна. /Он тус бүрийг хавсралт №1, 2-т харуулав/

Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлд тус хуулийн үйлчлэх хүрээ, 15.1-д шимтгэл төлөх хугацаа, хувь хэмжээг тодорхой заасан байна.

Аймгийн хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалын санд шимтгэл төлөгч болон тэтгэвэр, тэтгэмжид хамрагдсан байдлыг харуулбал дараах байдалтай байна. /Дүрслэл №1/

Нийт нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ААНБ, иргэдийн мэдээлэл

Дүрслэл №1



Нийт нийгмийн даатгалын сангийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдсан байдал



Дүрслэл №2

Нийгмийн даатгалын санд нийт шимтгэл төлөгчдийн 59 хувь нь НДС-ийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдсан байна. /Дүрслэл №2/

1.1.1 Сангийн хөрөнгийн зарцуулалтыг төлөвлөхдөө холбогдох тооцоо, судалгаанд үндэслэсэн байна. /1.1.2/

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 8.4¹, Нийгмийн даатгалын тухай хуулийн 12.2-т Нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийг боловсруулах цаглабарыг заасан байна. Үүний дагуу аймгийн НДХ-ээс дараа оны төсвийн төсөөллийг тухайн оны 7 дугаар сард боловсруулан, НДЕГ-т хүргүүлсэн байна.

2012-2018 онуудад сангийн хөрөнгийн төсвийн төсөөллийг боловсруулахдаа НДЕГ-аас ирүүлсэн төсөв боловсруулахад анхаарах чиглэлийг баримтлан, тэтгэвэр, тэтгэмжийн сантай холбоотой судалгаа, тайлан, статистик мэдээ, хөндлөнгийн байгууллагууд, тухайлбал, аймгийн УБХэлтэс, Татварын хэлтсээс авсан мэдээлэл зэрэгт үндэслэн, байгууллагын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг боловсруулж, төсвийн танилцуулгын хамт НДЕГ-т хүргүүлсэн байна. Сангийн хөрөнгийн батлагдсан төсөв, зарцуулалтыг аудитад хамрагдсан хугацааны нийт өссөн дүнгээр харуулбал дараах байдалтай байна. /Хүснэгт №2/

¹ 8.4.2-т “ төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаггүй төсвийн шууд захирагч жил бүрийн 8 дугаар сарын 01-ний дотор жилийн төсвийн төслөө харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх”

Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангийн 2012-2018 онуудын төсвийн төсөөлөл, батлагдсан төсөв, гүйцэтгэлийн харьцуулалт /сая.төгрөг/

Хүснэгт №2

Нийгмийн даатгалын сангийн төрөл	Төсвийн төсөөлөл	Батлагдсан	Гүйцэтгэл
Тэтгэврийн даатгалын сан	122,800.8	155,258.8	156,777.9
Тэтгэмжийн даатгалын сан	16,011.5	13,028.7	13,254.9
Нийт дүн	138,812.3	168,287.5	170,032.8


/Сангийн 2012-2018 онуудын төсвийн төсөөлөл, төлөвлөгөө, гүйцэтгэлийг хавсралт №7-д харуулав/

Дээрх судалгаанаас үзэхэд тэтгэврийн даатгалын сангийн төсөв нь хүргүүлсэн төсөөллөөс илүү дүнгээр батлагдсан байгаа нь тус онуудад иргэд нийгмийн даатгалын нөхөн даатгалд хамрагдсанаар төлсөн шимтгэл, тэтгэврийн хувь хэмжээ нэмэгдүүлэх Засгийн газрын 2013 оны 153, 81 дүгээр тогтоол, цалин хөлс нэмэгдүүлэх Засгийн газрын 2014 оны 208, 332, 333 зэрэг тогтоолууд батлагдсантай холбоотой байна.

Харин тэтгэмжийн даатгалын сангийн төсөв нь хамрагдсан хугацаанд төсвийн төсөөлөлд тусгаснаас хасагдаж батлагдсан байгаа ч жил бүрийн төсвийг авч үзвэл өмнөх оноос 4-22 хувиар тус тус нэмэгдэн батлагджээ. Энэ нь Засгийн газрын тогтоолоор цалингийн жишиг шинэчлэгдсэн, НДҮЗ-ийн тогтоолоор оршуулгын тэтгэмжийг 300.0-1000.0 мянган төгрөг хүртэл нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.


Батлагдсан төсвийг үндэслэлтэй тооцсон эсэхийг авч үзэхэд 2012-2018 онуудад тэтгэвэр, тэтгэмжид хамрагдсан хүний тоо жил бүр нэмэгдсэнтэй холбоотой сангийн хөрөнгийн зарцуулах төсөв өссөн үзүүлэлттэй байна. /График №1/

Тэтгэвэр, тэтгэмжид хамрагдсан иргэдийн тоо байдал



МУ-ын Нийгмийн даатгалын тухай хуулийн 10.1.5-д НДС-д улсын төсвөөс санхүүжилт олгохоор заасны дагуу 2012-2018 онд нийт 72072.6 сая төгрөгийн татаас санхүүжилтийг олгожээ. Энэ нь тус сангийн нийт орлогын төсвийн 31 хувийг эзэлж байна. Улсын төсвөөс олгосон санхүүжилтийн 97.8 хувь буюу 70503.6 сая төгрөгийг тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын санд хуваарилан зарцуулсан байна. /График №2/

Улсын төсвөөс олгосон санхүүжилтийн хэмжээ /сая төгрөг/



Аймгийн НДС-ийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг жил бүрээр авч үзэхэд дунджаар 22 хувь буюу 65862.8 сая төгрөгөөр давж биелсэн байгаа нь тухайн онуудад зарим/төмөр замын/ байгууллагын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой ба энэ хэмжээгээр улсын төсвөөс олгох санхүүжилтийн хэмжээг бууруулах боломж байна.

Сангуудад 2012-2018 онд хуваарилсан санхүүжилтээс дараа сард болон дараа оны эхний сард олгох тэтгэвэр, тэтгэмжийн тооцооллыг хийн арилжааны банкин дахь харилцах дансанд үлдээж, зарцуулаагүй чөлөөт үлдэгдэл болох 4795.7 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

1.1.2 Орлогыг бодитой тооцож хуваарилаагүйгээс сан хооронд шилжүүлэн зарцуулсан байна. /1.1.3/

Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлд “... нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг хууль тогтоомжид заасан болзол журмын дагуу тэтгэвэр тэтгэмж олгох, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх болон хууль тогтоомжид заасан бусад төлбөр, зардлыг санхүүжүүлнэ” гэж заасан байна.

Мөн Нийгмийн даатгалын тухай хууль болон Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд зааснаар өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэврийг тэтгэврийн даатгалын сангаас, хөдөлмөрийн чадвар түр алдалтын, жирэмсэн, амаржсаны болон оршуулгын тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын сангаас санхүүжүүлэх ба мөнгөн хөрөнгийн бие даасан сантай байна гэж хуульчилсан байна.

2012-2018 онд тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас нийт 93821 иргэнд, 170032.8 сая төгрөгийг зарцуулсан байна. /Хүснэгт №3/

Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангийн зарцуулалт /2012-2018/

Хүснэгт №3

№	Нийгмийн даатгалын сангийн төрөл		Батлагдсан төсөв	Хамрагдсан хүний тоо	Зарцуулсан төсөв /сая төгрөг/
1	Тэтгэврийн даатгалын сан	Өндөр насны тэтгэвэр	116,237.4	35546	116,567.6
2		Тахир дутуугийн тэтгэвэр	18,121.5	7379	18,334.1
3		Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	8,467.2	3454	8,689.0
4		Цэргийн тэтгэвэр	12,432.7	2467	13,187.1
Дүн			155,258.8	48846	156,777.9
1	Тэтгэмжийн даатгалын сан	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	3,200.6	34885	3,087.3
2		Жирэмсний болон амаржсаны тэтгэмж	8,404.5	8070	8,786.8
3		Оршуулгын тэтгэмж	1,423.6	2020	1,380.8
Дүн			13,028.7	44975	13,254.9
Нийт дүн			168,287.5	93821	170,032.8


Аудитаар МҮЕА-ын 2018 оны А/151 тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитад түүвэрлэлтийг ашиглах заавар”-ын дагуу тэтгэвэр шинээр тогтоолгосон нийт иргэдийн мэдээллээс түүвэрлэлт хийж, тэтгэврийг хууль тогтоомжид заасны дагуу тогтоосон эсэхэд аудит хийлээ.

Тэтгэврийн даатгалын сан:

Аймгийн хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар тэтгэврийн даатгалын сангаас нийт 8263 иргэн, 4 төрлийн тэтгэвэрт хамрагдсан байна. Харин 2012-2018 онд нийт 5356 иргэн шинээр өндөр настны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэврийг тогтоолгосон байна. /Дүрслэл №3/

Гүйцэтгэлийн аудитад түүвэрлэлт хийх зааврын дагуу санамсаргүй түүвэрлэлтийн аргаар шинээр тэтгэвэр тогтоолгосон нийт 939 хүний холбогдох анхан шатны баримтыг тэтгэврийн программ дахь мэдээлэлтэй тулган шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаа иргэдийн мэдээлэл



- Нийгмийн даатгалын дэвтэр, хөдөлмөрийн дэвтрийг нээсэн хугацаанаас өмнөх ажил эрхлэлтийн байдлыг нотлох тушаал, шийдвэр байхгүй, зөвхөн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг үндэслэн тухайн үеийн ажил эрхлэлтийг тасралтгүй гэж үзэн ажилласан жилийг дэвтэрт бичигдсэн хугацаагаар тооцсон байна. Тухайлбал:

- Иргэн Д.А-ын өндөр насны тэтгэврийг тооцоходоо 1968.01.19-ний өдөр шинээр нээсэн хөдөлмөрийн дэвтэрт 1967.05.10-ны өдөр ажилд орсон тухай бичилтээр ажил эрхлэлтийг программд оруулсан.
- Иргэн Б.Б-ын өндөр насны тэтгэврийн ажилласан жилийг тооцоходоо 1979.01.17-ны өдөр шинээр нээгдсэн хөдөлмөрийн дэвтэрт 1973.05.04-ний өдөр ажилд орсон дэвтрийн бичилтээр ажил эрхлэлтийг программд оруулсан.

- Сайн дурын нийгмийн даатгалын шимтгэл төлөлт болон ажилласан хугацааны цалин хөлсийг тэтгэврийн программд дутуу, алдаатай шивж оруулснаар тэтгэвэр тооцох дундаж цалинг зөрүүтэй тооцсон байна. Тухайлбал:

- Иргэн П.Б-ийн хувь тэнцсэн тэтгэврийн дундаж цалинг 1977 оны 1-4 дүгээр сарын цалин 135 төгрөг байхад 1350 төгрөг болгон 10 дахин нэмэгдүүлэн оруулж тооцсон.
- Иргэн Ц.Ц-ийн 2012 оны 10-12 дугаар саруудад сайн дурын даатгалын гэрээний дагуу төлсөн шимтгэлийг тэтгэвэр тооцох дундаж цалингийн хэмжээнд оруулаагүй.
- Иргэн Б.Б-ын өндөр насны тэтгэврийн цалин хөлсийг оруулахдаа 2007 оны цалингаас 93.1 мянган төгрөг, 2008 онд 658.5 мянган төгрөгийн цалинг тус тус дутуу оруулж дундаж цалин хөлсийг тооцон тэтгэвэр тогтоосон.

Дээрх зөрчлүүд нь 2012-2013 онуудын аудитын түүвэрт хамрагдсан хувийн хэргүүдэд илэрсэн. Иймд тухайн онуудын түүвэрт хамрагдаагүй бусад тэтгэвэр шинээр тогтоолгосон иргэдийн хувийн хэргийн бичиг баримтын бүрдэлд дахин нягтлан шалгалт хийж, зөрчлийг арилгах шаардлагатай байна.

Мөн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6², 10³ дугаар зүйлд тэтгэвэр олгох хугацааг заасан байна. Гэтэл аудитаар 2016 онд 2 иргэнд 481,0 мянган төгрөг, 2018 онд 2 иргэнд 590,0 мянган төгрөгийн нас барсны дараа сарын тэтгэврийг олгоогүй орхигдуулсан, нас барснаас хойш 2012 онд 384,7 мянган төгрөг, 2013 онд 145,2 мянган төгрөг, 2015 онд 230,0 мянган төгрөг, 2016 онд 211,1 мянган төгрөг, нийт 5 иргэнд 1,0 сая төгрөгийн 1 сарын тэтгэврийг илүү тооцож олгосон байна.

Тус зөрчлийг аудитын хамрах хугацаанд хөндлөнгийн болон дотоод хяналт шалгалтуудаар илрүүлэн залруулж байсан боловч давтагдан гарч байгаа тул нас баралтын мэдээнд үндэслэн хяналтыг сайжруулж, нас барсны дараа олгох тэтгэврийг бүрэн олгох тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4.1⁴-т тэтгэвэр тогтоох нөхцлийг тодорхойлсон байна. Гэтэл 2017 онд дээрх хуульд заасан тэтгэвэр тогтоох нөхцөл, шаардлагыг хангаагүй, энэ хуулиар заасан шалгуурыг үл харгалзан Монгол Улсын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24.6⁵, 24.7⁶-дахь заалтыг үндэслэн тэтгэвэр тогтоолгох эрх үүсээгүй байхад 55 нас хүрээгүй 1 иргэнд өндөр насны тэтгэвэр тогтоож, 2013-2017 онд хамаарах тэтгэврийг тооцож нийт 37.4 сая төгрөгийг нөхөн олгожээ.

Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 4.2.1⁷-т заасан хуулийн хамрах хүрээнд шүүхийн байгууллага хамаарч байхад салбар хуулиар тэтгэвэр тогтоох насыг тусад нь хуульчилсан байгаа нь эдгээр хуулиуд хоорондоо уялдахгүй, зөрчилдөж байна.

Нөхөн даатгалд хамрагдсан байдал

Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийн нөхөн тооцох тухай хууль 2012 онд батлагдсантай холбогдон ажилласан жилийн тасарсан хугацааг нөхөх зорилгоор 1995-2000 оны хугацаанд хөдөлмөр эрхлээгүй, нийгмийн даатгалын шимтгэл төлөгдөөгүй, төлөх боломжгүй байсан нийт 10715 иргэнийг нөхөн даатгалд хамруулахаар батлагдснаас 9280 иргэн тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 10 хувиар тооцон, 554.9 сая төгрөгийн шимтгэл нөхөн төлж, нийгмийн даатгалд хамрагдсан байна. /Хүснэгт №4/

Хүснэгт №4

Хамрах хугацаа	Хамрагдсан иргэний тоо	Төлсөн шимтгэлийн дүн /сая төгрөг/
2013	6821	430.3
2014	1495	66.1
2015	270	15.7
2016	408	23.9
2017	66	4.4
2018	220	14.5
Дүн	9280	554.9

² Өндөр насны тэтгэврийг даатгуулагч өргөдлөө тэтгэвэр тогтоолгох насанд хүрэхээс өмнө гаргасан бол уг насанд хүрсэн өдрөөс, хэрэв тэтгэвэр тогтоолгох насанд хүрснээс хойш гаргасан бол өргөдлийг даатгагч хүлээн авсан өдрөөс эхлэн, нас барсны дараагийн сар дуустал олгоно.

³ Тахир дутуугийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа алдсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, хэрэв тэтгэвэр авагч нас барвал нас барсны дараагийн сар дуустал олгоно.

⁴ Даатгуулагч нь нийтдээ 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 65 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Харин 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн бөгөөд 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй даатгуулагч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч болно.

⁵ Тавин таван насанд хүрсэн шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэврээ тогтоолгож болно.

⁶ Шүүгчээр нийт 25 жил ажилласан шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно.

⁷ /өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

Мөн тус хуульд нөхөн даатгалд хамрагдах иргэдийн насны хязгаар, бусад нөхцөл шаардлагыг тодорхой зааж өгөөгүй байна. Нөхөн даатгалд хамрагдсан иргэдийн судалгаанаас харахад нийт 9280 иргэн нөхөн даатгалд хамрагдсанаас 1974 оноос хойш төрсөн, 16 настай 135 иргэн 5-11 жилийг нөхөн тооцуулсан байна.

Энэ нь дээрх хууль хэрэгжснээр нөхөн даатгалын шимтгэлийн орлогоор НДС-ийн төсвийн тодорхой хувийг бүрдүүлсэн хэдий ч ирээдүйд дээрх иргэд тэтгэвэр тогтоолгох үед төсөвт ачаалал үүсэх эрсдлийг бий болгож байна.

Мөн аудитаар аймгийн УБХ-ээс 2012-2018 онд нас барсан иргэдийн судалгааг авч, нийгмийн даатгалын сангийн тэтгэвэр олголтын программ /Pension/ дахь мэдээлэлтэй тулгаж үзэхэд ирүүлсэн мэдээлэл нь алдаатай байснаас аудитын явцад цаг хугацаа алдах, буруу мэдээлэлд үндэслэн илрүүлсэн зөрчлийг дахин нягтласан болно. Нийгмийн даатгалын хэлтэс болон Улсын бүртгэлийн хэлтсүүдийн ажлын уялдаагүй байдлаас шалтгаалан мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийхэд хүндрэлтэй байлаа.

Тэтгэмжийн даатгалын сан:


Тэтгэмжийн даатгалын сангаас 2012-2018 онд нийт 44975 иргэнд 13254.9 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна. Тэтгэмжийн сангийн хөрөнгийн 78 хувийг ХЧТА-ны тэтгэмжийн зардлыг санхүүжүүлэхэд зарцуулсан байна. /Дүрслэл №4/

Гүйцэтгэлийн аудитад түүвэрлэлт хийх зааврын дагуу санамсаргүй түүвэрлэлтийн аргаар нийт 504 иргэнд хууль тогтоомжоор тогтоосны дагуу тэтгэмж олгосон байдлыг шалгалаа.

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох тухай хуулийн 18.1⁸-т хөдөлмөрийн чадвар алдсан иргэнд тэтгэмж олгох хувь хэмжээг заасан байна.

Аудитаар иргэдийн ХЧТА-ын тэтгэмжийг НД-ын байгууллагаас хянахдаа эмнэлгийн хуудсанд ажил олгогчийн тодорхойлсон шимтгэл төлсөн хугацааг шимтгэлийн программ, мэдээллийн баазтай тулган баталгаажуулаагүйгээс тэтгэмж бодох хувь хэмжээг илүү, дутуу зөрүүтэй тооцож олгосон байна. Энэ нь нийгмийн даатгалын байгууллагын тэтгэмжийн улсын байцаагч нь даатгуулагчид олгосон тэтгэмж олголтод хяналтыг бүрэн тавиагүйгээс 2012-2013 онд 5-14 жил шимтгэл төлж ажилласан 5 иргэний даатгуулагчийн тэтгэмжийг 55 хувиар тооцохоос 50 хувиар тооцож 17.9 мянган төгрөгийг дутуу, 1.3 жил шимтгэл төлж ажилласан 1 даатгуулагчийн тэтгэмжийг 50 хувиар тооцохоос 55 хувиар тооцож 5.1 мянган төгрөгийн тэтгэмжийг илүү тооцож олгосон байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас зарцуулсан зардлын хувь хэмжээ



⁸ Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг харгалзан түүний сүүлийн бүтэн ажилласан гурван сарын хөдөлмөрийн хөлснөөс дор дурдсан хувь хэмжээгээр бодож олгоно:

2018 онд ХЧТА-ны тэтгэмж олгосон нийт иргэний эмнэлгийн хуудсыг шалгахад Талст зам ӨЭМТ-өөс 3 иргэний үзлэгийг “Health info” программд бүртгээгүй байхад олгосон байх ба тус эмнэлгээс 2018 онд 654 хүний үзлэгийн мэдээлэл тодорхойгүй шалтгаанаар программаас устсан гэсэн тайлбарыг аудитын хугацаанд албан бичгээр ирүүллээ.

ХАХНХ-ын сайдын 2015 оны А/30 дугаар тушаалаар батлагдсан “Иргэн /даатгуулагч/-д эмнэлгийн хуудас олгох” журмын 2.4.1⁹-т эмнэлгийн хуудас олгох байгууллагыг тодорхой заасан байхад иргэн Б.Э нь Улаанбаатар хотын Гэмтэл согог заслын үндэсний төвд үзүүлж, аймагт Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасагт үзүүлсэн байхад Гоёо мэнд өрхийн эмнэлгээс 2018.04.12-2018.04.25-ны өдрийг хүртэл хугацаанд эмнэлгийн хуудсыг олгож, ХЧТА-ны тэтгэмжид 147.6 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 28.4-т заасан эмнэлгийн мэргэжилтний хүлээх үүрэг, Эрүүл мэндийн статистик мэдээллийн талаар авах арга хэмжээний тухай хуулийг тус тус зөрчсөн төдийгүй, эмнэлгийн хуудсыг хянах нийгмийн даатгалын хариуцсан байцаагчийн хяналт хангалтгүйгээс дээрх зөрчил гарсан байна.

Мөн 2012-2018 онуудад тэтгэмжийн даатгалын сангаас ХЧТА-ны тэтгэмж авах эрх үүссэн 62, ЖАТэтгэмж авах 24, оршуулгын тэтгэмж авах 3, нийт 89 иргэнд олгох, 29.8 сая төгрөгийн тэтгэмжийг тухайн иргэдийн ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгт суутган тооцож, шилжүүлээгүй байна.

Энэ нь Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан болзол журмын дагуу шимтгэл төлж нийгмийн даатгалд даатгуулсан иргэн хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж авах эрхтэй” гэсэн заалтыг зөрчиж шимтгэл төлөгчийн НДС-аас үйлчилгээ авах эрхийг хязгаарласан байна.

Тухайлбал 2012-2015 онуудад Чандмань Илч ОНӨХХК-ний ажилчдад олгох тэтгэмжийг байгууллагын шимтгэлийн авлагад суутган тооцсон байдлыг /Хүснэгт №5/-аар харуулав.

⁹ Ердийн болон ахуйн осол, ҮОМШӨ-өөр өвчилж стационар, амбулаториор эмчлүүлсэн, даатгуулагчид тусламж үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллага эмнэлгийн хуудсыг олгоно.

Чандмань Илч ОНӨХХК-ний төлөх өглөгт суутган тооцсон тэтгэмжийн тооцоо

Хүснэгт №5

Хамрах хугацаа	ХЧТА олгох хүний тоо	Тэтгэмжийн дүн /сая төгрөг/	Жирэмсэн амаржны тэтгэмж олгох хүний тоо	Тэтгэмжийн дүн /сая төгрөг/	Оршуулгын тэтгэмж олгох хүний тоо	Тэтгэмжийн дүн /сая төгрөг/	Өглөг, авлагаар суутган тооцсон дүн
2012 он	33	4.6	4	2.9	1	0.3	7.7
2014 он	10	0.9	3	2.8	1	0.6	4.3
2015 он	19	1.4	17	15.8	1	0.6	17.8
Нийт дүн	62	6.8	24	21.5	3	1.5	29.8

Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т “Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулах, зориулалтын бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглоно” гэж заасан байна.

Гэтэл арилжааны банкин дахь тэтгэмжийн сангийн харилцах дансдын ажил гүйлгээг үзэхэд сангуудын хөрөнгийн хуваарилалтыг тодорхой тооцоололгүйгээр, санхүүжилт дутагдалтай байгаа сангуудын данс хооронд шилжүүлэн зарцуулсан зөрчил нийтлэг илэрч байна. Тухайлбал 2012 онд Хаан банкин дахь тэтгэврийн даатгалын сангаас 5.0 сая төгрөгийг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 3.4 сая төгрөгийг тус тус тэтгэмжийн даатгалын сангийн дансанд шилжүүлэн зарцуулсан байх ба 4-17 хоногийн дараа дээрх сангийн дансад буцаан шилжүүлж, санхүүжилтийг залруулан бүртгэсэн байна.

1.1.5 Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Монгол Улсын Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль нь 1999 оны 06 сарын 10-ны өдөр буюу одоогоос 20 жилийн өмнө батлагдсан байна.

Тус хуулинд нэрийн дансны орлого нь дансны эхний үлдэгдэл, ажил олгогч болон даатгуулагчаас төлсөн шимтгэл, төрөөс төлсөн шимтгэл, дансны орлогод тооцсон хүүгээс бүрдэнэ гэж заасан байна. Мөн хуулийн 13 дүгээр зүйлд “Тэтгэвэр тогтоолгох болзол хангасан даатгуулагч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5¹⁰ дугаар зүйл, эсхүл энэ хуулийн 8¹¹ дугаар зүйлд заасан нөхцөлөөс сонголт хийж болно” гэж заажээ.

Тус аймагт 2012-2018 онд нийт шинээр тэтгэвэр тогтоолгохдоо иргэд дээрх хуульд заасан сонголтыг хийж Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох тухай хуульд заасан аргачлалаар тооцжээ. Учир нь тэтгэврийн тооцоолол хийхэд тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тооцоолол нь харьцангуй бага дүнгээр тогтоогддогтой холбоотой байна. Мөн иргэн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансаар тооцооллыг сонгосон тохиолдолд одоо ашиглагдаж байгаа программ тооцооллын томьёолол оруулах шинэчлэл хийгдээгүй, тэтгэврийг хэрхэн яаж олгох талаарх эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй байна.

¹⁰ Өндөр насны тэтгэврийн хэмжээ, нэмэгдэл

¹¹ Тэтгэврийг тооцох

1.1.6 Сангийн хөрөнгийн зарцуулалтад дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлж байгаа ч зөрчил байсаар байна.

Дотоод хяналтыг 2012-2017 онуудад холбогдох байцаагч нар тэтгэвэр, тэтгэмж тогтоох тухай бүрт шат шатны хяналтыг тавьж иржээ.

Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэхдээ 2018 оноос эхлэн “Monitoring” хяналтын программ хангамжийг ашиглан хэрэгжүүлж байна. Тус программ нь тэтгэвэр, тэтгэмжийн программаас мэдээлэл татах хянах, программ дахь цалин хөлсний өөрчлөлт, устгал зэргийг илрүүлэн мэдээлдэг байна. Программтай холбоотой шинэчлэлийг алдаа гарсан тухай бүрт мэдээлж, шинэчлэлийг тухай бүр хийдэг байна.

2017 онд НДЕГ-ын даргын 2017 оны 4 сарын 2-ны өдрийн 2/1153 дугаар албан бичгээр ирүүлсэн үүрэг чиглэлийн дагуу “Тэтгэвэр тогтоолт, олголтыг шалгах аян”-ыг зохион байгуулсан байна. Тус шалгалтаар улсын байцаагчийн 25.3 сая төгрөгийн зөрчил бүхий 12 акт тогтоож, 24 иргэнд дутуу олгосон 13.2 сая төгрөгийн тэтгэврийг нөхөн олгосон байна. Мөн хувийн хэргийн үзлэгээр 90 тэтгэвэр авагчийн хувийн хэргийн материалд дахин бүрдүүлэлт хийсэн байна.

Тэтгэврийн даатгалын санд давхардсан тоогоор нийт 6054 хүний хувийн хэрэгт шалгалт хийж 244.2 сая төгрөгийн тэтгэвэр илүү олгосон, 7 хүний 3.5 сая төгрөгийн тэтгэвэр дутуу олгосон зөрчил илрүүлсэн байна.

2018 онд байгууллагын хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулан мэдээллийн сан болон шинээр нийгмийн даатгалын гэрээ байгуулсан сайн дурын даатгуулагч нарын хувийн хэрэгт шалгалт хийж, хамтран ажиллах гэрээ байгуулсан арилжааны банкны тэтгэвэр олголтын байдалтай танилцсан байна. Шалгалтаар нийт Сайншанд, Даланжаргалан, Айраг, Сайншанд сумын 5-р баг, Улаанбадрах сумдын сайн дурын даатгуулагчийн хувийн хэргийг хамруулж, бүрдэл дутуу хувийн хэргийн зөрчлийг арилгуулахаар холбогдох албан тушаалтанд үүрэг өгч ажилласан байна.

Тэтгэмжийн даатгалын сангийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хүрээнд дээрх сумдад эмнэлгийн хуудас олголтын байдалд шалгалт хийсэн байна. Шалгалтаар эмнэлгийн хуудасны олголтыг Healt info-3 программтай тулгахад программд эхний болон давтан үзлэгийг бүрэн шивээгүй, эмнэлгийн хуудас олгосон бүртгэл хангалтгүй, эмнэлгийн хуудасны огноо засвартай, эрхлэгч эмчийн гарын үсэггүй зэрэг зөрчил илрүүлж, тус зөрчилд улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлсэн байна.

Мөн НДЕГ-ын даргын А/164 тоот тушаалын дагуу Нийгмийн даатгалын байгууллагын мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй даатгуулагчдын оршуулгын тэтгэмж олголтод хяналт шалгалтыг зохион байгуулсан байна. Шалгалтаар 2017-2018 онуудад нас барсан иргэдийн мэдээллийг нийгмийн даатгалын болон УБЕГ-ын мэдээллийн санг харьцуулан тулгахад сангуудын мэдээлэл зөрүүтэй байсанд залруулга хийлгэх хүсэлтийг НДЕГ-ын Дотоод аудит мониторингийн газарт хүргүүлсэн байна.

2012-2018 онд тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой 442 байгууллага, 103 иргэний тэтгэмж олголттой холбоотой 50.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, улсын байцаагчийн төлбөрийн акт тогтоосон байна. Шалгалтаар нийтлэг илэрсэн зөрчлийг дурьдвал:

- Өндөр насны тэтгэвэр тооцох дундаж цалинг буруу тооцсон
- Нас барсан хүний тэтгэврийг үргэлжлүүлэн олгосон.
- Тэжээгчээ алдсаны тэтгэврийг насанд хүрсэн хүүхдэд олгосон.
- Тэтгэвэр тооцох ажилласан жилийг зөрүүтэй оруулсан.
- Эмнэлгийн хуудас олгох журам зөрчсөн зэрэг зөрчилтэй байна.

Дотоод хяналтаар дээрх зөрчлүүдийг илрүүлж, холбогдох арга хэмжээг авч ажилласан, дотоод хяналтын үйл ажиллагаанд цахим программ хангамжийг нэвтрүүлснээр аудитад хамрагдсан хугацаанд дотоод хяналтаар илрүүлсэн зөрчлийн хэмжээ буурсан төдийгүй хяналт хэрэгжүүлэх ажилтнуудын ажлыг хялбаршуулж, зөрчлийг тухай бүр илрүүлэн залруулах боломж бүрдсэн боловч аудитаар зөрчил давтагдан гарсан байна.


1.2. Иргэдэд эрүүл мэндийн даатгалын сангаас үзүүлэх тусламж үйлчилгээний талаарх мэдээллийг таниулах, сурталчлах байдал хангалтгүй байна.

Аймгийн ЭМД-ын тасаг нь 2012-2017 онуудад аймгийн НДХ-ийн харъяанд ажиллаж, Засгийн газрын 2017.12.13-ны өдрийн “Агентлаг байгуулах тухай” 344 дүгээр тогтоолоор ЭМНДЕГ-ын ЭМД-ын санг тусгаарлаж Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд ЭМДЕГ-ыг шинэчлэн зохион байгуулж, Дорноговь аймагт ЭМД-ын тасаг нь 3 орон тоотойгоор ажиллаж байна.

Монгол Улсын Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3.1.6-д “ЭМД-ын сан гэж даатгуулагчид эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлийг хуваалцах зорилгоор төр, иргэн, хуулийн этгээдээс төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ” гэж заажээ.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19-р зүйлийн 19.3-т “Энэ хуулийн 19.1.1, 19.1.2, 19.1.8-д заасан шимтгэл, алдангийг цуглуулах, төвлөрүүлэх үйл ажиллагааг нийгмийн даатгалын байгууллага гүйцэтгэх бөгөөд үүнтэй холбогдсон харилцааг Нийгмийн даатгалын тухай хуулиар зохицуулна” мөн НДЕГазар, ЭМДЕГазрын дарга нарын баталсан Хамтран ажиллах 2018.03.22-ны өдрийн 22/18 дугаартай гэрээгээр ЭМДСангийн шимтгэлийн орлогыг цуглуулж баталгаажуулах, төвлөрүүлэх, уг хөрөнгийг ЭМДСанд шилжүүлэх, тайлагнах ажлыг дээрх гэрээгээр зохицуулсан байна. /Дүрслэл №5/

Дүрслэл №5




1.2.1 Сангийн хөрөнгийн зарцуулалтын төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна. /1.2.3/

2012-2017 онуудад НДЕГ-аас төсвийн төсөл, төсөөлөл ирүүлэх тухай чиглэлийг жил бүр хүргүүлэн ажилласан байх ба тус чиглэлийн дагуу гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудаас жил бүрийн 6 дугаар сард “Ирэх 5 жилийн төсвийн төсөл, төсөөлөл”-ийг холбогдох маягтын дагуу бэлтгэн НДЕГ-т, 2018 оноос ЭМДЕГ-т хүргүүлэн батлуулсан байна.

ЭМДС-ийн орлогын төлөвлөлт, зардлын гүйцэтгэлийн судалгаанаас харахад 2012-2018 онуудад төлөвлөгөө жил тутам нэмэгдэн батлагдсан, гүйцэтгэл нь батлагдсан төсвийн 90 орчим хувийг эзэлж байна. /График №3/

График №3



МУ-ын Иргэний ЭМД-ын тухай хуулийн 5.5-д “Даатгалын зөвлөл нь аймаг, нийслэлд орон тооны бус зөвлөлтэй байна. Салбар зөвлөлийн ажиллах журмыг даатгалын зөвлөл батална”, 9.3-т “ЭМДС-ийн 10 хувьтай тэнцэх хөрөнгийг болзошгүй эрсдэлийн нөөцөд үлдээж болох бөгөөд түүний зарцуулах журмыг НДҮЗ батална”, 9.4-т ЭМДС-ийн хэмнэгдсэн үлдэгдлийг НДҮЗ-ийн шийдвэрийг үндэслэн хүн амд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, тэдгээрийн хүртээмж, хамралтыг нэмэгдүүлэхэд зарцуулж болно” гэсэн байх боловч аудитад хамрагдсан хугацаанд тус аймагт эрсдэлийн нөөц санг бүрдүүлээгүй байна.

1.2.3. Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байна. /1.2.4/

Монгол Улсын Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19-р зүйлийн 19.4-т заасны дагуу НДЕГ-аар ЭМДС-ийн холбогдох дансанд мянган төгрөгийн, 2018 онд 6449,0 сая төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлжээ.

НДҮЗ-ийн 2014 оны 17 дугаар тогтоолын I хавсралтаар “Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийг урамшуулах журам”-ын 2.1-т заасан нөхцөлийг хангасан даатгуулагчийг эрүүл мэндийн урамшуулах үзлэгт хамруулна гэж заасны дагуу 231 иргэнийг урамшуулалд хамруулж 18,5 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

НДЕГ-аар, ЭМДЕГ-аар хоорондын байгуулсан 22/18 дугаартай гэрээний 2.1.8-д “НДЕГ нь төвлөрүүлсэн хөрөнгийг 7 хоног бүрийн даваа гаригт ЭМДС-ийн харилцах дансанд шилжүүлнэ” гэж заасан байна. Гэтэл НДС-ийн нийт орлогоос ЭМДС-д хуваарилалтыг буруу тооцсоноос 2017 онд 6114,9 сая төгрөгийг, 2018 онд 6082,0 сая төгрөгийг шилжүүлэх байтал 2017 онд 7058,6 сая төгрөгийг, 2018 онд 6493,3 сая төгрөгийг шилжүүлж, нийт 1355,0 сая төгрөгийг илүү хуваарилжээ.

/Тус илүү олгосон санхүүжилтийг 2019 онд тооцоо нийлж, төвлөрүүлэх санхүүжилтээс суутган тооцсон байна/

Эрүүл мэндийн сайдын 2009 оны 180 дугаар тушаалын II хавсралтаар батлагдсан “ЭМДС-аас санхүүжих тусламж үйлчилгээний төлбөрийн арга, зардлын хэмжээг тооцох журам”, ЭМС, СС, НХХС-ын хамтарсан 2011 оны 438/273/А-146 тушаал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 19 дүгээр тогтоолын 3-р хавсралтаар батлагдсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас тусламж үйлчилгээний зардлын төлбөр гүйцэтгэх журам”, УИХурлын 2016 оны 45-тогтоолоор батлагдсан “Засгийн газрын 2016-2020 он үйл ажиллагааны хөтөлбөрт заасны дагуу улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад хувьсах зардлаар тооцож санхүүжилтийг олгосон байна.

/ЭМДС-аас улсын болон хувийн хэвшлийн эмнэлгүүд, эмийн сангуудад олгосон, хянаж шилжүүлсэн санхүүжилтийг хавсралт №8-д харуулав/

Аудитад хамрагдсан хугацаанаас 2013, 2018 онуудын санхүүжилт олгосон байдлыг авч үзэхэд улсын эмнэлгүүд гүйцэтгэлээр 1632,0 сая төгрөгийг нэхэмжилснээс 1558,7 сая төгрөгийг хянаж олгосон, хувийн хэвшлийн эмнэлгүүд 79,4 сая төгрөг нэхэмжилснээс 78,1 сая төгрөгийг, эмийн сангууд 183,7 сая төгрөг нэхэмжилснээс 181,3 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, жилийн нийт дүнгээр 77,1 сая төгрөгийн санхүүжилтийг хасч олгосон байна.

2018 онд улсын эмнэлгүүд гүйцэтгэлээр 4363,5 сая төгрөгийг нэхэмжилснээс 4263,3 сая төгрөгийг хянаж олгосон, хувийн хэвшлийн эмнэлгүүд 204,4 сая төгрөг нэхэмжилснээс 201,7 сая төгрөгийг, эмийн сангууд 515,3 сая төгрөг нэхэмжилснээс 515,3 сая төгрөгийн, өрх, сумын ЭМТ-үүд 10,7 сая төгрөг, Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөрийн С вирусын эмийн үнийн хөнгөлөлтийн санхүүжилтэд 256,4 сая төгрөгийг тус тус нэхэмжилэн санхүүжилтийг 100 хувь олгож, жилийн нийт дүнгээр 102,8 сая төгрөгийн санхүүжилтийг хасч олгосон байна.

Улсын болон хувийн хэвшлийн эмнэлгүүдийн ЭМДТ-т ирүүлсэн гүйцэтгэлийг холбогдох албан тушаалтан хянаж, даатгуулагчдын регистрийн дугаарыг буруу шивсэн, оношийн бүлэг зөрүүтэй, өвчний түүх бичилт хангалтгүй, өөрийгөө санаатай гэмтээсэн өвчтөнд тусламж үзүүлсэн, хэвтэн эмчлүүлэх хугацаандаа амбулаторийн оношилгоо шинжилгээний тусламж үйлчилгээ давхардуулан авсан зэрэг шалтгааныг үндэслэн санхүүжилтийг холбогдох дүрэм, журамд заасны дагуу хасч олгосон байна.

НДЕГ-ын даргын 2016 оны А/83 тушаалын I хавсралтаар батлагдсан Гэр бүлийн-гишүүн даатгуулагчийн зардлыг шилжүүлэн тооцох журмын дагуу 2018 онд 7 иргэнд гэр бүлийн гишүүдийн даатгуулагчийн зардлаас 1949,8 мянган төгрөгийн зардлыг шилжүүлэн зарцуулсан байна.

Иргэд ЭМДС-аас өндөр өртөгтэй мэс заслыг III шатлалын эмнэлэгт хийлгүүлэх зардлын 75 хувийг төлүүлэх, урьдчилсан үзлэг, шинжилгээнд хамрагдах, Элэг бүтэн монгол хөтөлбөрийн хүрээнд элэгний В, С вирусын шинжилгээ үнэ төлбөргүй хийлгэх, үнэ төлбөргүй эм авах, орон нутгийн рашаан сувилалд хөнгөлөлттэй үнээр амрах зэрэг олон боломжит нөхцлүүд байгаа боловч иргэд энэ талаар мэдээлэл муу байгаагаас үйлчилгээг хангалттай хүртэж чадаагүй байна.

Тухайлбал: Элэг бүтэн Монгол-2 хөтөлбөр 2017 оноос хэрэгжиж эхэлснээс хойш аймгийн хэмжээнд нийт 43000 иргэн хамрагдахаас одоогийн байдлаар 23565 иргэн хамрагдсан үзүүлэлттэй байна.

ЭМДҮЗ-ийн 2017 оны 03 дугаар тогтоолын II хавсралтаар батлагдсан Эрүүл мэндийн даатгалын байгууллагын дүрмийн 3.1.5-д “Ерөнхий газар нь ЭМД-ын хууль тогтоомжийг олон нийтэд сурталчилах, таниулах, иргэн /даатгуулагч/-ийг ЭМД-ын талаар зохих мэдлэгтэй болгох арга хэмжээ авах үүрэгтэй, 4.1.2-т “Аймгийн ЭМД-ын байгууллага нь ЭМД-ын хууль тогтоомжийг сурталчилах үүрэгтэй” гэсэн заалтуудыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

1.2.4 Хөнгөлөгдөж байгаа эмийн тоо, хөнгөлөх хувь хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой эмийн сангуудад олгох санхүүжилтийн батлагдсан төсөв хүрэлцдэггүй байна /1.2.5/

Монгол Улсын Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14-р зүйлийн 14.9.10-т “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох” гэсэн заалтын дагуу Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016.03.25-ны өдрийн 08-р тогтоол, 2016.05.17-ны өдрийн 18-р тогтоол, 2018.06.25-ны өдрийн 10-р тогтоол, 2018.12.27-ны өдрийн 24-р тогтоолуудаар Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг баталжээ.

Мөн НДЕГ-ын даргын 2016.04.12-ны өдрийн А/74 тоот тушаал, 2018.07.31-ний өдрийн А/86-р тушаалаар Эрүүл мэндийн даатгалын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журмын дагуу ЭМДСангаас гэрээт эмийн сангуудын ирүүлсэн гүйцэтгэлийг хянаж, жилд дунджаар 4,2 сая төгрөгийг хасч олгосон байна. /Хүснэгт №7/

Эрүүл даатгалын сангаас гэрээт эмийн сангуудад олгосон санхүүжилтийг хянасан байдал

Хүснэгт №6

2013 он			2014 он			2015 он			2016 он			2017 он			2018 он		
Гүйцэтгэл	Хянаж олгосон	Хасагдсан дүн	Гүйцэтгэл	Хянаж олгосон	Хасагдсан дүн	Гүйцэтгэл	Хянаж олгосон	Хасагдсан дүн	Гүйцэтгэл	Хянаж олгосон	Хасагдсан дүн	Гүйцэтгэл	Хянаж олгосон	Хасагдсан дүн	Гүйцэтгэл	Хянаж олгосон	Хасагдсан дүн
183.7	181.3	2.4	248.7	245.2	3.5	382.2	377.1	5.2	487.1	479.7	7.3	565.1	562.5	2.6	515.3	515.3	0

ЭМДСЗ-ийн 2011 оны 03 тоот тогтоолын хавсралтаар “ЭМДС-аас зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журам” баталсан.

Дээрх журмын 3.8-д заасны дагуу эмийн зааврыг батлагдсан маягтаар бичээгүй, эмийн нэр, тун, хэмжээг буруу, алдаатай бичсэн, засварласан, тамга тэмдэг, эмчийн код, гарын үсэггүй, гаргацгүй бичсэн, жорын хүчинтэй хугацаа дууссан, мөн эмийн тунгийн хугацааг буруу бичсэн, 1 жоронд 3-аас дээш эм бичсэн, хөнгөлөлтгүй эм бичсэн, эмийн жорыг ерөнхий нэршлээр бичээгүй зэрэг нийтлэг зөрчлөөс шалтгаалан эмийн санхүүжилтийг хянаж, хасч тооцсон байна.

Аудитаар даатгуулагчдад олгох эмийн үнийн хөнгөлөлтийн жорыг татаж авч үзэхэд Эмийн жорын маягт, жор бичилт MNS 5376:2014 стандартын 8.2-т “Энгийн эмийн жорыг 1 жил, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жорыг 2 жил хадгална” гэж заасны дагуу гэрээт эмийн сангууд 2012-2016 онуудын жорыг устгасан талаар албан бичгээр тодорхойлолт гаргаж ирүүлсэн болно.

Улсын хэмжээнд 2018 оны 05 сараас эхлэн “Жорын цахим систем” хэрэгжиж эхэлсэн. Үүнээс өмнө НДЕГазрын “HIS” программыг ашиглан хяналтыг тавьж иржээ. Шинэ систем ашиглаж эхэлсэнтэй холбоотойгоор 2018 оны 5-12 саруудад жорын цахим системд эмийн сангууд, өрх, сумын ЭМТөвүүдийн ЭМДШ төлөлт, бусад холбогдох мэдээллийг бүрэн оруулсан боловч тус системд тулгалт хийхэд гацдаг зэргээс шалтгаалж хяналт тавих боломжгүй байдаг ба зарим тохиолдолд эмийн сангуудын санхүүжилтийг нэхэмжлэхийн дүнгээр ЭМДЕГ-аас шууд олгосон байна.

Тус цахим системийг ашиглаж эхэлснээс хойш одоог хүртэлх хугацаанд байнгын шинэчлэлтүүдийг хийж байгаа боловч саатал гарсаар байгаагаас эмийн сан, ӨЭМТөвүүд, эрүүл мэндийн байгууллагууд, даатгуулагч иргэдийн дунд үл ойлголцох асуудал үүсч, ард иргэдийн санал гомдол тасрахгүй байна.

ЭМДТ-аас жил бүрийн 6 дугаар сард гэрээт эмийн сангуудын төсөв, төсөөллийг авч нэгтгэн ЭМДЕГ-т явуулдаг боловч төсөв нь явуулсан төсөөллөөс бага хэмжээгээр батлагдаж ирдэг, хөнгөлөгдөж байгаа эмийн тоо, хөнгөлөх хувь хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой эмийн сангуудад олгож байгаа санхүүжилт төсөв хүрэлцдэггүй байна.

Аймгийн ЭМДТ-аас эмийн сангуудтай даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээг 2015 оныг дуустал аймгийн ЭМГ-тай, 2016-2017 онуудад НДХ-тэй, 2018 оноос ЭМДЕГазар нь эмийн сангуудтай байгуулж хамтран ажиллаж байна.

ЭМДЕГ-ын даргын 2018 оны А/142 тушаалын хавсралтаар батлагдсан “Даатгалын гэрээ дүгнэх журам”-ын дагуу гэрээг хагас, бүтэн жилээр тогтмол дүгнэж, цаашид хамтарч ажиллах эсэхийг шийддэг байна. Дээрх журамд гэрээг тодорхой шалгуураар дүгнэж, гэрээг үргэлжлүүлэх, шинэчлэн байгуулах, түдгэлзүүлэх, цуцлах гэсэн арга хэмжээг авахаар заасан байх боловч эмийн сангууд гэрээний чиг үүргээ удаа дараа хангалттай биелүүлсэн тохиолдолд тус эмийн санд олгох санхүүжилтийг нэмэгдүүлэх, урамшуулах нөхцлийг тусгаж өгөөгүй, мөн ирэх жилийн төсөв батлахад эмийн сангийн гэрээг дүгнэсэн үнэлгээг харгалзаж үздэггүйгээс санхүүжилтийн хуваарилалт нь оновчгүй хийгдэж байна.

Гэрээт эмийн сангуудын ажил дүгнэсэн байдлыг олгосон санхүүжилттэй харьцуулан харуулвал дараах байдалтай байна. /Хүснэгт №7/

Гэрээт эмийн сангуудад олгосон санхүүжилт

Гэрээт эмийн сангуудын нэр	2017 онд олгосон санхүүжилт /сая.төг/	Нийт санхүүжилтийн дүнд эзлэх хувь	Гэрээ дүгнэсэн оноо /хувь/	2018 онд олгосон санхүүжилт /сая.төг/	Нийт санхүүжилтийн дүнд эзлэх хувь	Гэрээ дүгнэсэн оноо /хувь/
Эм импекс	90.1	15.8	90	120.1	18.8	83
Ганга фарм	32.6	5.7	86	32.6	5.1	86
Монос	35.2	6.2	88	35.2	5.5	83
Гүн хөх	24.4	4.3	89	24.4	3.8	86
Брайву сүм	44.7	7.8	89	64.7	10.1	88
Увидаст тан	32.9	5.8	87	32.9	5.1	96
Шанд фарм	4.3	0.8	83	4.3	0.7	
Эм эргэлтийн сан /13 сум/	197.5	34.6	80	194.6	30.4	91
Мандах нар	45.1	7.9	86	45.1	7.1	94
Долгион	4.3	0.8	87	24.3	3.8	93
Төгөлдөр фарм	51.6	9.0	88	61.5	9.6	93
Жигдэн дан ван	4	0.7				
Ундрам	4	0.7				
Нийт дүн	570.7	100.0		639.7	100	

Дээрх эмийн сангуудад олгосон санхүүжилт, ажил дүгнэсэн байдлыг уялдуулж харахад орчин нөхцөл бүрдсэн, эмийн хангалт сайтай эмийн сангуудад санхүүжилт бага хэмжээтэй хуваарилагдсан, дараагийн жилд төсөв нэмж батлагдаагүй байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2018 оны 1-5 сарын хугацаанд даатгуулагчдад үзүүлсэн тусламж үйлчилгээний зардлын гүйцэтгэлээс даатгалын байцаагч эмч 60 даатгуулагчийн 15699,3 мянган төгрөг, амбулаторын тусламж үйлчилгээ авсан 710 даатгуулагчийн 11043,6 мянган төгрөг, оношилгоо, шинжилгээ хийлгэсэн 704 даатгуулагчийн 11526,4 мянган төгрөг, нийт 38269,3 мянган төгрөгийн зардлыг хасч тооцсоныг ЭМДЕГ-азрын даргын 2018.08.28-ны өдрийн 05/739 тоот албан бичгээр олгуулахаар шийдвэрлэж санхүүжилтийг нөхөн олгосон байна.

1.2.5 Байгууллагын бүтцэд өөрчлөлт орохоос өмнө дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлээгүй байна. /1.2.6/

Аймгийн ЭМДТ нь НДХ-ийн харьяанд байхад тус хэлтсээс ЭМДС-ийн орлого бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалтын байдалд дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлж байгаагүй, эрүүл мэндийн даатгалын хяналтын байцаагч эмч нь ажлын үндсэн чиг үүргийн дагуу гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаа болон даатгуулагчдад үзүүлсэн ЭМ-ийн тусламж үйлчилгээний зардлын гүйцэтгэлд тухай бүр зохих хяналтыг тавьж иржээ.

2014 онд Халзан уул рашаан сувиллын үйл ажиллагаанд хяналт хийж, сувилуулагчийн түүхийг давхардуулан бичсэн 110,0 мянган төгрөгийн илүү санхүүжилт авсан зөрчил илрүүлэн улсын байцаагчийн акт тогтоон барагдуулсан байна.

2017 оны хагас жилийн байдлаар хийсэн шалгалтаар эмнэлгийн 4 байгууллагад 2996 даатгуулагч иргэний 135,0 мянган төгрөг, 23 эмийн сангийн, 101 даатгуулагч иргэний 356,9 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, эм тариа, боох материалыг

даатгуулагчдаас гаргуулсан, ЭМДШ төлөөгүй иргэдэд үйлчилгээ үзүүлсэн зэрэг зөрчлүүдэд холбогдох зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Мөн тус онд НДХ-ийн даргын удирдамжаар “Эерэг хандлага-чанартай үйлчилгээ”-ний жил болгон зарласантай холбогдуулан даатгуулагчдад эмийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээний явцад хяналт хийж, 90-ээс дээш хувийн эмийн хангалт нөөцтэй байх, тогтоосон үнийн дээд хязгаараас илүү үнээр эм худалдахгүй байх, даатгалтай эмээр үйлчилгээ үзүүлэх талаар мэдээллийг даатгуулагчдад хүргэх ажлыг зохион байгуулах талаар зөвлөмж хүргүүлэн ажиллажээ.

Монгол Улсын Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 24-р зүйлийн 24.2-д “Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь дотоод хяналтын нэгжтэй байх ба дотоод хяналтын нэгжийн дүрмийг Нийгмийн даатгалын байгууллага баталж мөрдөнө” гэж заасны дагуу ЭМДЕГ-ын даргын 2018.11.01-ний өдрийн Журам батлах тухай А/23-р тушаалын 2-р хавсралтаар Эрүүл мэндийн даатгалын хяналт шалгалтын журмыг баталжээ.

НДЕГ-ын даргын удирдамжаар 2013 онд “Иргэний ЭМД-ын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэг, УАУТөв, Ачлал, Идэр Өлзийт хувийн эмнэлгүүд, аймгийн төвийн 6 эмийн сан, Зүүнбаян СДЭ, Замын Үүд сумын Нэгдсэн эмнэлэг, Халзан Уул рашаан сувилалын 2012 оны үйл ажиллагааг хамруулан хийж, эмнэлгүүд оношийн хамааралтай бүлгийг буруу тогтоож нэхэмжилсэн зэрэг зөрчилд холбогдох арга хэмжээг авч ажиллажээ.

ЭМДЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд 2018 онд Дорноговь аймагт тусламж үйлчилгээ үзүүлж байгаа Эрүүл мэндийн даатгалын гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд 5 хүний бүрэлдэхүүнтэй хяналт шалгалтыг 2018 оны 05 дугаар сард гүйцэтгэж хяналт шалгалтын ажлын тэмдэглэлийг хүргүүлсэн боловч шалгалтын тэмдэглэлд цаашид тасаг хэрхэн яаж ажиллахыг тодорхой дурьдаагүй, шалгалтын мөрөөр ямар арга хэмжээ авсан эсэх нь тодорхойгүй байна.

1.3 ҮОМШӨ-ний даатгалын сан, ажилгүйдлийн даатгалын санд хяналтыг тогтмол хэрэгжүүлж байгаа хэдий ч алдаа зөрчил давтагдсаар байна.

1.3.1 Сангийн төсвийг өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслэлгүй төлөвлөж байна.

ҮОМШӨ-ний даатгалын сан:


Монгол Улсын Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулиар 2 төрлийн тэтгэвэр, 1 төрлийн тэтгэмж болон хуульд заасан бусад төлбөр, зардлыг санхүүжүүлэхээр заажээ.

ҮОМШӨ-ний даатгалын санд аудитын хамрах хугацаанд 14323.9 сая төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлж, сангаас 2012-2018 онуудад өссөн дүнгээр нийт 6454.4 сая төгрөгийг зарцуулахаар батлагдсанаас 96 хувь буюу 6210.7 сая төгрөгийг зарцуулсан байх ба нийт орлогын 43 хувийг тэтгэвэр, тэтгэмжид зарцуулж, 57 хувь нь хэмнэгдсэн байна. /Дүрслэл №5/



Ажилгүйдлийн даатгалын сан

Ажилгүйдлийн даатгалын сангийн аудитад хамрагдсан хугацааны төсвийн төсөөлөл, батлагдсан төсөв, зардлын гүйцэтгэлийн харьцуулсан судалгаанаас харахад сангийн төсөв нь жил бүрийн хүргүүлсэн төсөөллийн 50 орчим хувиар батлагдсан байх ба сангийн зарцуулалтын бодит гүйцэтгэлийг авч үзэхэд жил бүр батлагдсан төсвийн дунджаар 80 орчим хувийг зарцуулсан байна.



Батлагдсан төсвийн бүрэлдэхүүнд сургалтын зардлын төсөв нь 2012 онтой харьцуулахад жил бүр нэмэгдэн батлагдсан байгаа боловч сүүлийн 7 жилийн хугацаанд зардлын гүйцэтгэл гараагүй байгаа нь уг зардлыг гүйцэтгэлд үндэслэж төлөвлөдөггүй, мөн НДҮЗ-ийн баталсан “Ажилгүйдлийн даатгалын

сангаас тэтгэмж олгох журам”-ын 6.3-т заасан хяналт тавих үүргийг НД-ын байгууллага хангалтгүй хэрэгжүүлсэн төдийгүй орон нутгийн хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллагатай ажилгүйдлийн тэтгэмж авсан иргэдийг сургах асуудлаар уялдаж ажиллаагүй байна. /Дүрслэл №7/

1.3.2 Холбогдох хууль тогтоомжийн зарим заалтыг зөрчиж тэтгэвэр, тэтгэмж олгосон байна.

ҮОМШӨ-ний даатгалын сан:

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 142 дугаар тогтоолоор ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн хэмжээг ангилал тус бүрээр тогтоосон байна. 2018 оны жилийн эцсийн байдлаар 651 ААНБ, 117669 иргэний ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийг төлсөн байна. Шимтгэлийн хэмжээг он тус бүрээр хүснэгтээр харуулав. /Хүснэгт №8 /

2012-2018 онуудад ҮОМШӨ-ний даатгалын шимтгэл төлөлт

Хүснэгт №8

Хамрах хугацаа	Шимтгэлийн хувь хэмжээ	Шимтгэл төлөгч ААНБ-ын тоо	Хамрагдах иргэдийн тоо	Шимтгэлийн орлогын дүн /сая.төг/
2012	0.8	326	11016	628.2
	1.8	58	1980	227.8
	2.8	44	3758	400.3
2013	0.8	365	10569	940.7
	1.8	63	2021	167.3
	2.8	49	3930	474.9
2014	0.8	373	10253	1044.1
	1.8	68	2120	284.7
	2.8	51	3950	569.5
2015	0.8	366	9001	1083.9
	1.8	78	2235	126.5
	2.8	57	3856	596.2
2016	0.8	483	9459	1284.9
	1.8	83	2384	377.7
	2.8	61	4423	895.2
2017	0.8	526	10626	1451.9
	1.8	63	2484	295.8
	2.8	51	4786	941.1
2018	0.8	526	11685	1252.3
	1.8	65	2450	325.9
	2.8	60	4683	955
Нийт дүн	0.8	2965	72609	7686
	1.8	478	15674	1805.7
	2.8	373	29386	4832.2

Аудитын хамрах хугацаанд ҮОМШӨ-ний даатгалын санд 4063 ААНБ-ийн, 146627 иргэдийн шимтгэлийг төвлөрүүлжээ. Үүнээс 1063 иргэн тахир дутуугийн тэтгэвэр, 897 иргэн тэтгэмжид хамрагдсан байна. /Дүрслэл №8/

Тус санд шимтгэл төлсөн иргэдийн тоог тэтгэвэр, тэтгэмжид хамрагдсан иргэдийн тоотой харьцуулан үзвэл шимтгэл төлөгчдийн зөвхөн 1 хувь нь тус сангийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдсан үзүүлэлттэй байна.

Мөн тус сангаас 7 жилийн хугацаанд 19 иргэн тахир дутуугийн тэтгэвэр, 15 иргэн тэжээгчээ алдсаны тэтгэмжийг шинээр тогтоолгожээ.



Монгол Улсын Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 16¹²-р заалтад “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 30 ба түүнээс дээш алдсан даатгуулагч рашаан сувилалд эмчлүүлэхтэй холбогдсон төлбөр авах эрхтэй” гэж заасан байна.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас жилд дунджаар 125 иргэн тахир дутуугийн тэтгэвэр авч байгаагаас үүний 50 орчим хувь буюу 64 иргэн рашаан сувилалд эмчлүүлж, 5,8 сая төгрөгийг олгосон байна.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас рашаан сувилалд эмчлүүлэх зардал олгосон байдлыг он тус бүрээр харуулбал дараах байдалтай байна. /Хүснэгт №9/

ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч иргэдээс рашаан сувиллын зардалд олгосон судалгаа /2012-2018 он/

Хүснэгт №9

Хамрах огноо	Тахир дутуугийн тэтгэвэр авагч иргэний тоо	ҮОМШӨ-ний даатгалын сангаас рашаан сувилалд эмчлүүлэх зардал олгосон иргэдийн тоо	Нийт тэтгэвэр авагчдын дүнд эзлэх хувь	Олгосон зардлын дүн /сая төгрөг/
2012	186	85	46%	5.9
2013	175	85	49%	6.4
2014	164	84	51%	6.4
2015	151	77	51%	5.7
2016	137	77	56%	6.1
2017	130	63	48%	5.8
2018	120	60	50%	4.2
Нийт	1063	531	50%	40.4

Монгол Улсын Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 16, 17 дугаар зүйлд ҮОМШӨ-ний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан, тахир дутуу болсон иргэдэд хиймэл эрхтэн, засал эмчилгээ хийлгэх, рашаан сувилалд эмчлүүлэх, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр авах эрхийн талаар тусгасан байх боловч дээрх судалгаанаас харахад хуулийн тус заалтуудын талаар иргэдийн ойлголт дутмаг, НД-ын байгууллагаас хуулийн сурталчилгаа мэдээлэл хангалтгүй хийж байгаагаас тус заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Аудитаар тус сангаас тэтгэвэр, тэтгэмж олгогдсон байдлыг түүвэрт хамруулан, хувийн хэрэг, бусад холбогдох баримт материалыг шалгахад дараах зөрчил илэрлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 10-12 дугаар зүйлд тэжээгчээ алдсаны тэтгэврийг олгох нөхцөл, хувь хэмжээ, хугацааг тус тус заасан байна.

¹² Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 30 ба түүнээс дээш хувиар алдсан даатгуулагч хиймэл эрхтэн, засал эмчилгээ /протез, ортопед/ хийлгэх, тэтгэврийн даатгалын шимтгэл төлөх рашаан сувилалд эмчлүүлэхэд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр авах эрхтэй

Гэтэл 2012 онд БНХАУ-ын иргэн Ван Шуаныг Голден погада ХХК-ний захирлын 2010.06.21-ний өдрийн 05/10 тушаалаар жолооч, орчуулагчаар томилон ажиллуулж, 2010.07.20-ны өдөр автын ослоор нас барсныг Нийслэлийн МХГ-ын улсын байцаагч 2010.09.10-ны өдрийн 11-13/474-1673 дугаартай актаар үйлдвэрлэлийн ослыг баталгаажуулсан, мөн НДЕГ-ын дэргэдэх Гомдлын шаардлагын зөвлөлөөс уг иргэний гэр бүлд тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгох талаар 2011.01..24-ний өдрийн 04 тоот албан бичгийг аймгийн НДХ-т ирүүлсний дагуу түүний асрамжид байсан гэх гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй 1 гишүүнд тэжээгчээ алдсаны тэтгэврийг сард 441,0 мянган төгрөгөөр тогтоож, 2018.12.31-ний өдрийн байдлаар нийт 52,6 сая төгрөгийн тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгосон байна.

Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгохоор бүрдүүлсэн баримтыг /хувийн хэрэг/ үзэхэд тэтгэвэр тогтооход хүчин төгөлдөр бус бичиг баримтыг үндэслэсэн байна.

Тухайлбал: Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 8.1.6-д “Монгол Улсын виз, оршин суух, бүртгүүлэх журам зөрчих, **эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хөдөлмөр эрхлэх, шилжин суурьшихыг хориглоно**”, 27.1-д “МУ-д хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийг гадаадын иргэний хүсэлт, холбогдох байгууллагын санал, зөвшөөрлийг харгалзан гадаадын иргэний асуудал эрхэлсэн ТЗ-ны байгууллага 5 хүртэл жилээр олгож, тухай бүр 3 хүртэл жилийн хугацаагаар сунгаж болно” гэж заасан байна.

Гэтэл тус гадаадын иргэний Монгол Улсад оршин суух үнэмлэхний хугацаа 2008.04.21-2009.08.22-ны өдрийг хүртэл хүчинтэй, нас барах үед манай улсад цагаачлах хугацаа дууссан байсан, гадаад иргэний эхнэр гэх Б.Марттай гэр бүл болсон талаар нотлох баримт байхгүй, гэрлэлт батлуулаагүй, түүний хүү гэх М.Адьяадоржийн эцгийг Иргэний хэргийн Дорноговь аймаг дахь Сум дундын I шүүхээр хэлэлцэж, “В.Шуан, Б.Март нар хамт амьдарч байсан болон М.Адьяадорж нь гадаад иргэний хүү болохыг нэхэмжлэгчийн тайлбар, гэрч нарын мэдүүлгээр тогтоогдож байна” гэж 2010.09.03-ны өдөр тогтоосон зэргээс харахад тэтгэвэр тогтооход хүчин төгөлдөр бус бичиг баримтыг үндэслэсэн нь тодорхой байна.

Иймд дээрх гадаадын иргэнтэй холбоотой YOMШӨ-ий даатгалын сангаас олгогдож байгаа тэжээгчээ алдсаны тэтгэврийг зогсоолгохоор албан шаардлага хүргүүллээ.


Мөн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 10 дугаар зүйлд “Тахир дутуугийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа алдсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, хэрэв тэтгэвэр авагч нас барвал нас барсны дараагийн сар дуустал олгоно” гэж заасан байна.

Гэтэл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс ирүүлсэн нас баралтын мэдээг тэтгэвэр олголтын программ дахь мэдээлэлтэй тулгахад 2015 онд иргэн Ч.Н-д нас барсны дараа сарын тэтгэвэр болох 536.1 мянган төгрөг, 2017 онд тахир дутуугийн тэтгэвэр авагч иргэн Л.Ю-д тахир дутуугийн тэтгэвэр 461.9 мянган төгрөгийн тэтгэврийг тус тус олгоогүй орхигдуулсан байна.

Ажилгүйдлийн даатгалын сан:

График №4

Ажилгүйдлийн даатгалын сангаас 2012 онд 354 иргэн тэтгэмж авч байсан бол 2018 оны байдлаар 607 иргэн тэтгэмж авч, сангийн зардлын гүйцэтгэл өссөн байна. /График №4/



Гүйцэтгэлийн аудитад түүвэрлэлт хийх зааврын дагуу санамсаргүй түүвэрлэлтийн аргаар АДС-аас 2012-2018 онуудад ажилгүйдлийн тэтгэмж авсан иргэдийн мэдээлэлд түүвэрлэлт хийж, нийт 161 иргэнд олгосон тэтгэмжтэй холбоотой холбогдох анхан шатны баримтуудыг тус тэтгэмжийн сангийн программ болон НДШ төлөлтийн программ дахь мэдээллийг тулган шалгахад дараах зөрчлүүд илэрлээ.

Монгол Улсын НДС-аас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар зүйлд ажилгүйдлийн тэтгэмжийг хөдөлмөр эрхлэлтийн алба, уг алба байхгүй бол нийгмийн даатгалын байгууллага сард 2 хүртэлх удаа тооцож олгохоор заасан байна.

Мөн НДҮЗ-ийн баталсан “Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журам”-ын 5.6-д “Тэтгэмж авагч нь АТ авч байх хугацаандаа ажилд орсон, тэтгэмж авах хугацаа дуусгавар болсон бол энэ тухайгаа НД-ын байгууллагад мэдэгдэн, тэтгэмж олголтыг зогсоож, тооцоо хийн, НД-ын дэвтрээ буцаан авах үүрэгтэй” гэж заасан байна.

Гэтэл тэтгэмж авагч нь тэтгэмж авсан хугацаандаа дараагийн ажилд томилогдон НДШ төлсөн байхад холбогдох ажилгүйдэл хариуцсан байцаагч хяналт тавьж ажиллаагүй, мөн ажилгүйдлийн тэтгэмжийг 1 удаа, нийт дүнгээр олгосноос 2013 онд нэр бүхий 3, 2014 онд 3, 2016 онд 2, нийт 8 иргэнд ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон тэтгэмжийн зөрүүг өнөөг хүртэл тооцож тус санд төвлөрүүлээгүй, тэтгэмж авагч НДШ төлж эхэлсэн хугацаанд тухайн иргэнтэй холбогдож ажилд томилогдсон тушаал шийдвэрийг бүрдүүлж хувийн хэрэгт хавсаргаагүй байна.

НДҮЗ-ийн баталсан “Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журам”-ын 5.5-д Тэтгэмж авагч нь өөрийн сурах сонирхолтой мэргэжлийн чиглэлээ тодорхойлж, хөдөлмөрийн байгууллагатай гэрээ байгуулсан эрх бүхий сургалтын байгууллагыг сонгон суралцах үүрэгтэй гэж заасан, сургалтын зардлыг жил бүр төсөвт тусгуулан батлуулж байгаа ч тэтгэмжид хамрагдсан иргэд энэ талаар мэдээлэлгүй, сургалтын зардал нь хэт бага хэмжээтэй тогтоогдсон, НДХ-ээс иргэдийг сургалтад хамруулах талаар орон нутаг дахь аймгийн ХХҮГ-тай хамтран ажиллаагүй байна.

1.3.3 Дотоод хяналтын тогтолцоо сайжирч, хяналтын үр нөлөө дээшилж байна.

Байгууллагын дотоод хяналт шалгалтаар ҮОМШӨ-ний сангийн үйл ажиллагаанд алдаа зөрчил илрээгүй байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн хяналт шалгалтын төлөвлөгөө, даргын баталсан удирдамжийн дагуу Нийгмийн даатгалын хууль, тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт сум орон нутгийн хэмжээнд хэрхэн хэрэгжиж байгаа болон сумдын байцаагчийн үйл ажиллагаа, ажлын гүйцэтгэлд хяналт шалгалтыг тогтмол хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр зохион байгуулсан байна.


Хяналтаар аж ахуйн нэгж байгууллагын ажилгүйдлийн тэтгэмжийн олголт, хувийн хэргийн тооллого хийж аудитад хамрагдсан хугацаанд илүү олгосон ажилгүйдлийн тэтгэмжийг төлүүлэхээр 46.5 сая төгрөгийн улсын байцаагчийн төлбөрийн акт тогтоосон байна.

1.5 Сангуудын авлагыг барагдуулах тодорхой арга хэмжээ авч ажилласан ч хуримтлагдсан авлагын дүн буураагүй байна.

1.5.1 Уул уурхайн компаниудын тогтмол бус үйл ажиллагаанаас шалтгаалж найдваргүй авлага үүссэн байна.

Аймгийн НДС-ийн шимтгэлийн авлагыг аудитад хамрагдах хугацаагаар харуулвал дараах байдалтай байна. /График №5/

НДШ-ийн авлага 2012 онтой харьцуулахад жил бүр өссөн үзүүлэлттэй байх ба 2018 оны жилийн эцсийн дүнгээс харахад нийт авлагын 59,7 хувь нь 30 хоногтой буюу хугацаа хэтрээгүй авлага, 23,3 хувь нь 120-оос дээш, 17 хувь нь 90 хүртэл хоногтой авлага эзэлж байна. /Хүснэгт №10/



Авлагын насжилтын судалгаа

Хүснэгт №10

Насжилт /хоногоор/	2012	2013	2014	2015	2016	2017	2018
0-30	494.6	601.6	1008.3	1234.8	509.4	750.3	905.5
31-60	3.5	19.2	91.6	99.7	78.6	57.4	160.5
61-90	119.2	30.4	48.5	92.9	74.3	43	66.6
91-120	0.5	25.6	54.6	87.9	68.9	40.8	29.2
120 дээш	4.1	421.3	93.6	478.1	462.2	269.1	353.8
Нийт дүн	621.9	1098.1	1296.6	1993.4	1193.4	1160.6	1515.6

Мөн 2012 оны авлагыг насжилтаар нь 2018 онтой харьцуулахад 2012 онд хугацаа хэтрээгүй авлага 80 хувийг эзэлж байсан бол 2018 онд 60 хувь болж, насжилт урттай авлагын хэмжээ өссөн байна.

Харин 2018 онд бүртгэгдсэн НДС-ийн авлага болох 1515.6 сая төгрөгийн, 19 аж ахуйн нэгжтэй холбоотой 523.3 сая төгрөгийн хуримтлагдсан авлага байна.

1.5.2 Авлагын насжилтад тохируулж тодорхой арга хэмжээ авч ажилласан байна.

График №6

Санхүүгийн тайланд тусгагдсан нийт авлагыг шимтгэл төлөгч байгууллагын төрлөөр харуулвал дараах байдалтай байна. /График №6/



Авлага үүсч байгаа шалтгааныг авч үзвэл төмөр замын байгууллагууд сарын сүүлийн цалинг дараа сарын 05-ны өдөр олгодогтой холбоотой 0-30 хоногийн авлага үүсдэг, төсөвт байгууллагуудын хувьд тухайн сарын шимтгэлийн зардлын төсөв хүрэлцэхгүйгээс сар дамнасан авлага үүсдэг, тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудын үйл ажиллагаа зогссон, татан буугдсантай холбоотой НДШ-ийн он дамнасан хуримтлагдсан авлага үүссэн байна.

2018 оны санхүүгийн тайланд тусгагдсан хуримтлагдсан авлага болох 523.3 сая төгрөгийн авлагыг барагдуулах ажлыг аймгийн НДХ-ээс зохион байгуулж, 26 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 87.0 сая төгрөгийн авлагын асуудлыг Шүүхэд шилжүүлэн шийдвэр гаргуулсан, ШШГАлба ажиллагаа явуулсны дүнд тус авлагаас 64.4 сая төгрөгийн авлагыг барагдуулсан, мөн 4 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 432,8 сая төгрөгийн шимтгэл төлөх гэрээ байгуулан, тодорхой хугацаанд төлөх график байгуулсан, 3 байгууллагын 14.5 сая төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулахаар харилцах дансыг хаан ажиллаж байна.

Мөн эзэн холбогдогч нь тодорхойгүй, аж ахуйн нэгж байгууллага татан буугдсан гэх 14.1 сая төгрөгийн авлагын асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд аймгийн Цагдаагийн газарт хандан эрэн сурвалжлуулах ажиллагааг гүйцэтгүүлж байгаагаас харахад хуримтлагдсан авлагыг барагдуулах талаар тодорхой ажлуудыг зохион байгуулсан байна.

БҮЛЭГ 2. Нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлсэн хөрөнгийн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

2.1 НДЕГ-аас ажиллагсдын нийгмийн хамгааллын зардалд 39.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

2.1.1 Холбогдох журамд заасан шалгуур хангасан ажилтнуудад дэмжлэг үзүүлсэн байна.

НДҮЗ-ийн 2013 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “НД-ын байгууллагын ажилтнуудад орон сууцны мөнгөн тэтгэлэг олгох” журмын 3.1-т заасны дагуу ажилтнуудын орон сууцны мөнгөн тэтгэлэг хүссэн тухай өргөдөл болон холбогдох материалыг хүлээн авсан он, сар, өдрийн дарааллаар бүртгэж, дарааллыг жил

тутам ажилтнуудад танилцуулан, 2012-2016 онуудад аймгийн НДХ-ийн нийт 8 ажилтны өргөдлийг НДЕГ-т хүргүүлж, дээрх ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зориулж нийт 39.8 сая төгрөгийг олгосон байна. Тэтгэлэгт хамрагдсан ажилтнууд нь аймгийн НДХ-т 6-19 жил ажилласан байх ба 2012 онд 6,0 сая төгрөгийн дэмжлэг авсан 1 ажилтан хуулийн дагуу 2016.08.25-ны өдөр өндөр насны тэтгэвэр тогтоолгож ажлаасаа чөлөөлөгдсөн, 2 ажилтан дээрх журмын 2.1.5-д заасан хугацааг хангаж ажлаасаа чөлөөлөгдсөн, бусад дэмжлэгт хамрагдсан ажилтнууд нийгмийн даатгалын байгууллагад өнөөдрийг хүртэл тогтвор суурьшилтай ажиллаж байна.

Мөн аудитын хамрах хугацаанд НДХ-ээс ажилтан, албан хаагчдад шагнал урамшуулал болон хуульд заасан бусад нөхөн олговрыг олгоогүй байна.

2.2 Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг үндэслэн ТАХ хэрэгжүүлсэн байна.

2.2.1 ТАХ-г хэрэгжүүлэх шаардлагыг тодорхой хүргүүлсэн байна.

Монгол Улсын ТБОНӨХБАҮХАТ хуулийн 7.1¹³-т худалдан авах ажиллагаанд баримтлах тендер шалгаруулалтын журмыг тусгасан байна.

Тус аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст шууд гэрээ байгуулах аргаар 2015 онд 1, харьцуулалтын аргаар 2015-2016 онд 2 худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Нийгмийн даатгалын 2012 оны төсвийн тухай хуулиар Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Нийгмийн даатгалын тасгийн барилгыг засварлах 20.7 сая төгрөг, 2016 оны хуулиар тавилга, эд хогшил худалдан авах 15.0 сая төгрөгийн төсвийг баталсан байна. Харин Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2015 оны 22 дугаар тогтоолоор тавилга, эд хогшил худалдан авах зардлыг 15.0 сая төгрөг, барилга байгууламжийн их засварын ажлын төсвийг 2015 оны 19 дүгээр тогтоолоор 60.3 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Дээрх ТАХ-г хэрэгжүүлэхдээ тавилга, эд хогшил худалдан авах хэрэгцээ шаардлагын судалгаа, барилгын их засварын зургийн дагуу төсөв боловсруулж, НДЕГ-т хүргүүлсэн байх боловч Замын-Үүд сумын Нийгмийн даатгалын тасгийн барилгад их засварын ажил хийх шаардлагатай гэсэн мэргэжлийн байгууллагын дүгнэлт байхгүй байна.

2.2.2 Барилгын ажлын техникийн нөхцөл болон бусад холбогдох зөвшөөрлийг дахин авах шаардлага үүсээгүй байна.

Барилга байгууламжийн их засварын ажил нь шинэ барилга биш учир шинээр газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл, инженер геологийн дүгнэлт зэрэг зөвшөөрөл авах шаардлага байхгүй байна.

2.2.3 ТЭЗҮ хийгдсэн, зураг төсөв батлуулсан ТАХ-г хэрэгжүүлсэн байна.

¹³ Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгийг сонгож гэрээ байгуулна:

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл, хийгдсэн зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасан.

2015 онд Замын-Үүд сумын НД-ын тасгийн барилгын их засварын ажлыг 60.3 сая төгрөгийн төсөвт өртгөөр гүйцэтгүүлэхээр 2014 онд мэргэшсэн төсөвчнөөр хийлгэсэн байна. Харин 2016 онд тавилга, эд хогшил худалдан авахад шаардагдах хөрөнгийн төсөв болон техникийн тодорхойлолтыг үнэлгээний хорооноос боловсруулж, төлөвлөсөн нь Барилгын тухай хуулийн 24.2¹⁴-т заасныг хэрэгжүүлж ажиллажээ.

2.2.4 ТАХ-ний зураг, төсөвт өөрчлөлт ороогүй байна.

Хэрэгжүүлсэн ТАХ-ны батлагдсан зураг төсвийн дагуу гүйцэтгэж, өөрчлөлт оруулаагүй байна.

2.2.5 Хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж ТАХ-г хэрэгжүүлсэн байна.

2015-2016 онуудад хөрөнгө оруулалтын ТАХ-г хэрэгжүүлэхдээ шаардлагатай тавилга эд хогшлын судалгааг жагсаалтаар бэлтгэн боловсруулж НДЕГ-т хүргүүлсэн байна.

2.3 Худалдан авах ажиллагаанд баримтлах хуулийн зарим заалтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

2.3.1 Үнэлгээний хороог худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшээгүй ажилчдаар бүрдүүлсэн байна.

Монгол Улсын ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47.6-д “Үнэлгээний хорооны гишүүд нь худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна” гэж заажээ. Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2015-2016 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаанд холбогдох хуульд заасны¹⁵ дагуу үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг байгууллагын даргын тушаалаар томилон ажиллуулсан байх боловч тус үнэлгээний хорооны гишүүдэд А-3 сертификаттай, худалдан авах ажиллагааны талаар мэргэшсэн ажилтан байхгүй байгаа нь хуульд заасан дээрх шаардлагыг хангахгүй байна. Мөн хуулийн 47.4¹⁶-т заасны дагуу үнэлгээний хороог байгуулах боломжтой байтал хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.3.2 Тендерийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу боловсруулсан байна.

Монгол Улсын ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлд үнэлгээний хорооны чиг үүргийг тусгасан байна. Үүний дагуу үнэлгээний хорооны гишүүд холбогдох журамд заасны дагуу худалдан авах ажил үйлчилгээ, барааны техникийн тодорхойлолт, тендерийн урилга, баримт бичгийг боловсруулж, хуулиар тодорхойлсон чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.

¹⁴ Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга байгууламжийн төсвийн тооцоог мэргэшлийн зэрэгтэй төсөвчнөөр хийлгэсэн байна.

¹⁵ ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1-д “Захиалагч нь үнэлгээний хорооны байгуулна” гэж заасан байна.

¹⁶ Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.

2015-2016 онд байгууллагын даргын тушаалаар томилогдсон үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг Монгол Улсын ТБОНӨХБАҮХАТ хуулийн 19.1-д заасны дагуу боловсруулж, тендерийн баримт бичигт оролцогчоос ирүүлэх баримтын бүрдэл, тавих шаардлага, техникийн тодорхойлолтыг тусгасан байна.

Мөн түүнчлэн худалдан авах ажиллагааг дээрх хуулийн 46.1.3¹⁷-т заасны дагуу үнэлгээний хорооны дүгнэлтэд үндэслэн гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулах эрх олгосон тушаал шийдвэр гаргах байтал үнэлгээний хорооны албан ёсны дүгнэлт, байгууллагын даргын тушаал шийдвэр гараагүй, зөвхөн тендер шалгаруулалтын үеийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан байна.

2.3.3 Тендерт оролцогчийг өрсөлдөх боломжоор хангасан байна.

Монгол Улсын ТБОНӨХБАҮХАТ хуульд¹⁸ худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулж байгаа бол захиалагч нь тендерийн урилгыг шаардлага хангах 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэнэ гэж заасан байна.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 2015 онд зохион байгуулсан Замын-Үүд сумын НДТ-ийн их засварын ажлын үнийн санал ирүүлэх урилгыг 4 этгээдэд, 2016 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны урилгыг 4 этгээдэд тус тус хүргүүлж, хуульд заасан шаардлагыг хангаж ажиллажээ.

2.3.4 Хууль тогтоомжид заасны дагуу худалдан авах ажиллагааны журмыг сонгосон байна.

Дээрх хуулийн 7 дугаар зүйлд зааснаар захиалагч нь бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан худалдан авах ажиллагаанд баримтлах босго үнийн дүнг харгалзан харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна. Тухайн онуудад худалдан авсан барилга байгууламжийн их засварын ажил нь нь 58.5 сая төгрөгийн, бараа худалдан авах ажил нь 14.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй байгаа нь босго үнийн хязгаарт хамаарч, хууль тогтоомжид заасан хувь хэмжээг баримтлан худалдан авах ажиллагааны журмыг сонгосон байна.

2.3.5 Тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн ч худалдан авах ажиллагааны баримтын бүрдэл хангалтгүй байна.

Захиалагч нь худалдан авах ажиллагааг тайлагнахдаа Монгол Улсын ТБОНӨХБАҮХАТ хуульд зааснаар тендерийн хавтаст хэрэг үүсгэн, архивын нэгж болгон хадгалахаар заасан байна.

Аймгийн НДХ-ийн худалдан авах ажиллагааны тендерийн баримтын архивын нэгжийг үзэхэд үнэлгээний хороо байгуулсан тухай даргын тушаал, тендерийн баримт бичиг, захиалагч болон тендерт оролцогчдын харилцсан албан бичиг, ажлын гүйцэтгэл, ажил хүлээж авсан акт зэрэг баримт бичгийг бүрдүүлсэн байна. Харин хуульд заасан бусад баримт бичиг болох худалдан авах ажиллагааны

¹⁷ Үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлтэд үндэслэн гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах.

¹⁸ ТБОНӨХБАҮХАТ хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1-д “Техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэнэ”

төлөвлөгөө, тендерт шалгараагүй оролцогчийн ирүүлсэн баримт материал, үнэлгээний хорооноос байгууллагын даргад хүргүүлсэн дүгнэлт, гэрээ байгуулах эрх олгосон байгууллагын даргын тушаал зэрэг баримт бичиг байхгүй, баримтын бүрдэл дутуу байна.

2.4 ТАХ-г гэрээнд заасны дагуу гүйцэтгэсэн байна.

2.4.1 Гүйцэтгэгч байгууллага ажил гүйцэтгэх гэрээнд заасан хугацааг баримтлан ажлыг бүрэн гүйцэтгэсэн байна.

Монгол Улсын ТБОНӨХБАҮХАТ хуулийн 40 дүгээр зүйлд бараа, ажил үйлчилгээг худалдан авах гэрээг байгуулах ба гэрээний үндсэн нөхцөлөөс гадна гэрээний үнэ, төлбөр хийх нөхцөл хэлбэр, урьдчилгаа төлбөр төлөх бол урьдчилгаа төлбөрийн баталгааны дүн, хэлбэр, захиалагчийн хяналт, гүйцэтгэлийн баталгааны дүн, хэлбэр, худалдааны нөхцөл, бараа, ажил үйлчилгээг гүйцэтгэх хуваарь зэргийг тусгана гэж заасан байна. Мөн Иргэний хуулийн 350 дугаар зүйлд "... ажил гүйцэтгэгч нь заасан ажлыг тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэнэ" гэж заасны дагуу 2015, 2016 онуудад зохион байгуулсан худалдан авах ажиллагааны гэрээнд дээрх шаардлагатай нөхцлүүдийг бүрэн тусгасан байна.

2015 онд Замын-Үүд сумын НДТ-ийн их засварын ажлыг 2015.07.02-2015.08.12-ны хугацаанд гүйцэтгэхээр Хул шанд ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байна. Гэтэл барилга байгууламж ашиглалтад оруулах комисс 2015.08.27-ны өдөр хүлээж авсан байх ба гүйцэтгэгч Хул шанд ХХК-иас ажил хүлээлгэн өгөх тухай мэдэгдлийг ирүүлээгүй байна.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулахад Монгол Улсын Барилгын тухай хуулийн 48 дүгээр зүйлийг баримтлах ба Засгийн газрын 2017 оны 69 дүгээр тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 2.1¹⁹-д заасны дагуу ажлыг зохион байгуулж, 4 дэх хэсэгт заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлснээр хүлээн авна гэж заасан байна.

Гэтэл дээрх барилгын их засварын ажлыг хүлээж авах үеийн баримтыг үзэхэд гүйцэтгэгч байгууллагын ашиглалтад хүлээлгэн өгөх хүсэлтийг гаргахаас өмнө дүрэмд заасны дагуу барилга байгууламжийн их засвар нь зураг төслийн дагуу хийгдсэн эсэхэд үзлэг хийгээгүй, ажил гүйцэтгэх үед зөрчил гарсан эсэх нь тодорхойгүй, ажил хүлээн авах комисс нь зөвхөн акт үйлдэн баталгаажуулж, хүлээн авсан байна.

2.4.2 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна" гэж заасан байна.

2015-2016 онд хэрэгжүүлсэн Замын-Үүд сумын НДТ-ийн их засварын ажилд НДҮЗ-ийн тогтоолоор 60.3 сая төгрөг, тавилга эд хогшил худалдан авах ажилд 15.0 сая

¹⁹ Захиалагч барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт гаргахаас өмнө ус, дулаан, уур, хий, цахилгаан, харилцаа холбоо зэрэг тухайн барилга байгууламжийн инженерийн хангамжийн асуудлыг хариуцсан байгууллага болон зураг төсөл зохиогч, гүйцэтгэгчтэй хамтран барилга байгууламжид үзлэг хийж, зөрчлийг арилгуулсны үндсэн дээр Барилгын тухай хуулийн 48.5.4-т заасан нэгдсэн дүгнэлтийг гаргасан байна.

төгрөг батлагдсанаас гэрээний дүнгээр гүйцэтгэгч байгууллагуудад санхүүжилтийг олгож, хөрөнгө оруулалтын үлдэгдэл болох 2.1 сая төгрөгийн улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

2.4.3 ТАХ-ний санхүүжилтийг гэрээнд заасан нөхцлийг үндэслэн шилжүүлсэн байна.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 41.2.6²⁰, Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.19-д “Захиалагч барилгын ажлын зардал, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн үнэ, техник хяналтын зардал, ...-ыг холбогдох баримт материалыг үндэслэн шилжүүлнэ” гэж заасан байна.

2015 онд 58.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Замын-Үүд сумын НДТ-ийн их засварын ажил гүйцэтгэх гэрээнд ажлыг 50 хувиас дээш хийж гүйцэтгэснээр эхний, ажил хүлээлцэж комиссын акт гарсны дараа үлдэгдэл 50 хувийн санхүүжилтийг олгоно гэж заасан байна. Үүний дагуу гүйцэтгэгч байгууллага ажил гүйцэтгэх гэрээ байгуулсны дараа буюу 2015.07.27-ны өдөр эхний 50 хувийн ажлын гүйцэтгэлийг гаргаснаар нийт санхүүжилтийн 50 хувь, 2015.08.25-ны үлдсэн ажлын гүйцэтгэлийг гаргаж, ажил хүлээн авснаас хойш буюу 2015.10.09-ний өдөр санхүүжилтийг бүрэн олгож, холбогдох хууль тогтоомж, ажил гүйцэтгэх гэрээнд заасны дагуу шилжүүлсэн байна. Санхүүжилтийг тооцоход барилгын засварын ажлын төсвийн тооцоонд магадлашгүй ажлын зардалд 1.0 сая төгрөг, захиалагчийн албаны зардалд 1.0 сая төгрөг тус тус тусгажээ.

Ажил гүйцэтгэх явцад төсөв өртгийн тооцоонд дутуу тусгагдсан гэх шалтгаанаар зарим ажлыг нэмэлтээр гүйцэтгэн холбогдох албан тушаалтан болон гүйцэтгэгч байгууллага магадлашгүй ажлын акт үйлдэн баталгаажуулж, санхүүжилтийг олгосон байна. Харин захиалагчийн хяналтын зардлыг гүйцэтгэгч компанид шилжүүлснийг аймгийн ГХБХБГ тус компаниас нэхэмжлэн авсан байна. Гэтэл ГХБХБГ-аас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх гэрээ байхгүй, хяналт хийсэн ажлын тайлан байхгүй байгаа нь Засгийн газрын 2009 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 2.2-т “Барилга байгууламжийг өөрийн санхүүжилтээр барьж байгаа иргэн, хуулийн этгээд нь **гэрээний үндсэн дээр** мэргэжлийн хүн, хуулийн этгээдээр барилга захиалгын ажлыг гүйцэтгүүлж болно” гэж заасантай нийцэхгүй байна.

Мөн 2016 онд 14.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий албан тасалгааны тавилга, эд хогшил худалдан авах гэрээнд барааг хуанлийн 10 хоногт багтаан, нийгмийн даатгалын хэлтэст 100 хувь хүлээлгэн өгснөөр санхүүжилтийг олгоно гэж тусгасан байна. Санхүүжилтийг баримтыг үзэхэд тавилга, эд хогшлыг 2016.05.09-ний өдөр хүлээлгэн өгч, 2016.05.09-ний өдөр санхүүжилтийг шилжүүлнэ гэж заасны дагуу гэрээнд заасан санхүүжилтийг хуваарийн дагуу олгожээ.

2.4.4 Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

²⁰ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх;

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 37.1.5²¹, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46.1.6²²-д, Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 4.1²³-4.2²⁴-т захиалагч хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар тус тус заасан байна.

2015 онд гүйцэтгэсэн Замын-Үүд сумын НДТ-ийн их засварын ажлын худалдан авах ажиллагааны архивын баримтыг үзэхэд захиалагчаас хяналтыг хэрхэн хэрэгжүүлсэн талаар баримт материал байхгүй, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулсан эсэх нь тодорхойгүй, энэ нь хууль тогтоомжоор олгосон үүргээ хэрэгжүүлээгүй байна.

2.5. Урсгал болон хөрөнгийн зардалд тавих хөндлөнгийн болон дотоод хяналтаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Хөндлөнгийн хяналт:

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар:

Аймгийн НДС-ийн 2012-2018 онуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар:

ҮОМШӨ-ний санд Аймгийн МХГ-аас 2018, 2019 онуудад хяналт шалгалт хийсэн байна. Хяналт шалгалтаар аймгийн хэмжээнд үйлдвэрлэлийн осол 30 удаа гарч, тухайн ослуудыг ААНБ-ын үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссоос судлан бүртгэж акт үйлдэж ирүүлснийг хянан баталгаажуулсан байна. Тухайн ослын акт хууль, дүрэмд нийцээгүй тохиолдолд улсын байцаагч дүгнэлт гаргана гэж заасны дагуу 2018 онд ААНБ-ын үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссоос судлан бүртгэж акт үйлдэж ирүүлсэн 3 ослын актыг хүлээн зөвшөөрч баталгаажуулалгүй улсын байцаагчийн дүгнэлт гаргажээ.

2018 онд гарсан үйлдвэрлэлийн ослыг нуун дарагдуулсантай холбоотой иргэнээс ирүүлсэн өргөдлийн мөрөөр хяналт шалгалт хийж, тус зөрчлийг илрүүлэн тухайн аж ахуйн нэгжийг 4.0 сая төгрөгөөр торгох арга хэмжээ авсан байна.

Мөн аймгийн МХГ-ын нийтэд зарлагдсан урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын объектын нэгдсэн төлөвлөгөө, МХЕГ-ын даргын баталсан 01/70 тоот удирдамжийн дагуу НДХ-ийн тэтгэвэр болон тэтгэмжийн даатгалын сангийн 2017, 20018 оны 1 дүгээр улирлын орлого, бүрдүүлэлт, зарцуулалтын дүнд хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар цэргийн тэтгэвэр авч байгаад нас барсан тэтгэвэр авагчид оршуулгын тэтгэмж олгоогүй, эмнэлгийн хуудас олголтод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн, шимтгэлийн өглөг, авлагын хэмжээ өссөн зэрэг зөрчил илрүүлж, 11 даатгуулагчид олгосон ХЧТА-ны тэтгэмжийг буцаан санд төлүүлэхээр

²¹ Барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах;

²² Захиалагч бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих

²³ Захиалагч нь төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд техникийн хяналт тавьж, хэмжилт шалгалтыг барилгын салбарт мөрдөж байгаа хууль болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан норм, норматив, дүрэм журмын дагуу явуулна.

²⁴ Захиалагч нь барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын, шууд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч ажиллана.

улсын байцаагчийн акт тогтоож, эмнэлгийн хуудсыг хянахдаа Health-info программтай тулган шалгалт хийж байхаар албан шаардлага хүргүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба:

Монгол Улсын сангийн сайдын баталсан удирдамж, СХАА-ны даргын баталсан 01 тоот удирдамжийн дагуу аймгийн НДХэлтсийн ЭМДСангийн /2017 онд ийм нэртэй байсан. Харин 2018 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхлэн ЭМДЕГазар болон тусдаа байгууллага болсон/ 2017-2018 оны сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар ЭМД-ын байгууллага, аймгийн болон Замын Үүд сумын Нэгдсэн эмнэлэг хоорондын байгуулсан Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээний зүйл заалтыг удаа дараа зөрчсөн байхад гэрээ дүгнэхэд харгалзан үзээгүй, сангийн хөрөнгөөс 8,6 сая төгрөгийг сан хооронд шилжүүлэн зарцуулсан, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төвүүдийн үзүүлсэн тусламж үйлчилгээний тайлангийн агуулга, мэдээ судалгаа хангалтгүй, холбогдох материалыг ирүүлдэггүй, өөрсдийн буруутай үйл ажиллагаанаас болж санхүүжилтээ хасуулдаг, ЭМДаатгалын харилцах дансанд гэрээнд заасан хугацаанд хүүгийн орлогыг төвлөрүүлээгүй, 31 өвчний түүхийн бүрдлийг нягталж үзээгүй, засч залруулах арга хэмжээ авалгүйгээр 4674,8 мянган төгрөгийг ЭМДС-аас олгосон, өдрийн эмчилгээний оношийн бүлэгт хамаарахгүй өвчний оношоор санхүүжилт нэхэмжилсэн зэрэг давхардсан тоогоор 185 хүнтэй холбоотой 21537,8 мянган төгрөгийн төлбөр зөрчил илрүүлж, ЭМДС-д төвлөрүүлэхээр 21537,8 мянган төгрөгийн улсын байцаагчийн 3 акт тогтоосноос 19627,6 мянган төгрөгийн, 2 актыг хүчингүй болгосон байна.

Холбогдох байгууллагын санал



**ДОРНОГОВЬ АЙМАГ
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС**

44107 Дорноговь аймаг, Сайншанд сум, 1 дүгээр баг,
Утас/Факс: (976) 7052 2311, Вэбсайт: www.daatgal.mn

2019.11.20 № 420

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Санал хүргүүлэх тухай

Танай байгууллагаас ирүүлсэн аудитын урьдчилсан дүгнэлтийн саналтай танилцлаа. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд аудит хийсэн дүгнэлттэй холбоотой санал тайлбарыг хүргүүлж байна.

1. Шалгалтанд хамаарах хугацаанд Тэтгэмжийн даатгалын сангийн дутагдлыг бусад сангаас илүү хуваарилах замаар шийдвэрлсэн тухай дурьдсанг хасуулах саналтай байна. 2012-2018 онд Тэтгэмжийн даатгалын сан нь батлагдсан төсвийн хүрээнд хүрэлцээтэй, төвлөрсөн сан үлдэгдэлтэй байсан бөгөөд тухайн үед ажилтны алдаанаас данс ташааруулан гүйлгээ хийж эргээд залруулгын гүйлгээ хийгдсэнийг Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулж хууль зөрчсөн мэтээр бичсэн байгааг эргэж харах нь зүйтэй байна.

2. Элэг бүтэн монгол хөтөлбөрийн хэрэгжилт, мэдээлэл муу байгаагаас өндөр өртөгтэй мэс засал хийлгүүлэх зардлыг авч чадахгүй, үйлчилгээг хангалттай хүртэж чадахгүй байгаа талаар дурдсан байна. Хөтөлбөрийг орон нутагт аймгийн ЭМГазар зохион байгуулахаар журамд заасны дагуу тус хэлтэс хамтран ажиллаж хамрагдсан даатгуулагчийг хянаж гүйцэтгэлээр санхүүжилтийг олгон ажилласан.

Хөтөлбөр хэрэгжсэн 2017, 2018 онуудад 23,6 мянган даатгуулагч хамрагдаж хэрэгжилт 54,8 хувьтай байсан.

Одоо хөтөлбөр үргэлжлэн хэрэгжиж байгаа болно. Өндөр өртөгтэй мэс заслын хагалгааг Дорноговь аймагт хийхгүй, зөвхөн улсын 3 дугаар шатлалын магадлан итгэмжлэгдсэн эмнэлгүүдэд хийдэг тул даатгуулагчдад мэдээллийг тухай бүр өгч ажиллаж байна. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын сургалт сурталчилгааны тайлангуудыг хавсаргав.

Даатгалын байгууллагын хувьд Эрүүл мэндийн салбарын байгууллагуудын хамрагдсан гүйцэтгэлд тулгуурлан санхүүжилт өгдөгийг дурьдах нь зүйтэй юм.

Дээрх 2 асуудлаар аудитын дүгнэлт тайлбараас хасуулах, эсвэл өөрчлөн найруулах замаар шийдвэрлүүлэх саналыг хүргүүлж байна.

ДАРГА  Я.ШАГДАРСУРЭН





ДОРНОГОВЬ АЙМАГ
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

44107 Дорноговь аймаг, Сайншанд сум, 1 дүгээр баг,
Утас/Факс: (976) 7052 2311, Вэбсайт: www.daatgal.mn

2019.11.15 № 410

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТИЙН ГАЗРЫН ДАРГА
Ч.АРИУНАА ТАНАА

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх гомдлын шаардлагын зөвлөлийн 2011 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 04 тоот тогтоолоор Зүүнбаян 5-р багийн иргэн Б.Мартын тэжээгчээ алдасны тэтгэврийг тогтоосон тул тус тэтгэвэртэй холбоотой асуудлыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх гомдлын шаардлагын зөвлөлд хандана уу.



ДАРГА  Л.ШАГДАРСҮРЭН

Э.Тухчээт
ЧАТ-7 үйлчилгээ
2019.11/15

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Аймгийн НДХ сангуудын төсвийн төслийг өмнөх онуудын бодит гүйцэтгэл, мэдээ судалгаанд үндэслэн боловсруулж НДЕГ-т хүргүүлдэг боловч хүргүүлсэн саналыг үндэслэхгүйгээр баталсан байна.
- НДШ-ийн орлогыг бодитой тооцож хуваарилаагүйгээс сан хооронд шилжүүлэн зарцуулсан байна.
- НД-ын байгууллагын хэмжээнд дотоод хяналтын тогтолцоонд ахиц гарч, алдаа зөрчлийн хэмжээ буурсан ч байгууллагуудтай мэдээлэл солилцох байдал, албан хаагчдын мэдлэг чадвар, ажлын хариуцлагатай холбоотой зөрчил гарсан байна.
- ЭМДС-аас үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг даатгуулагчдад сурталчилан таниулах үйл ажиллагаа хангалтгүй байгаагаас иргэд хууль тогтоомжоор олгосон эрхээ бүрэн эдэлж чадаагүй байна.
- Хөнгөлөгдөж байгаа эмийн тоо, хөнгөлөх хувь хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой эмийн сангуудад олгохоор батлагдсан санхүүжилт хүрэлцдэггүй байна
- НДШ-ийн авлага өсөх хандлагатай байгаа ч хуримтлагдсан авлагыг бууруулах талаар шат дараалсан арга хэмжээ авч ажиллаж байна.
- НДЕГ-аас худалдан авах ажиллагаа болон ажиллагсдын нийгмийн хамгааллын зардлыг санхүүжүүлж ажилласан байна.
- Хөндлөнгийн хяналт шалгалтын байгууллагууд хууль тогтоомжид заасан үүргийг хэрэгжүүлсэн байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ НЬ:

1. ҮОМШӨ-ний даатгалын сангаас хуульд заасан шаардлага хангаагүй гадаадын иргэний гэр бүлд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоох шийдвэр гаргаж, сангийн хөрөнгийг зүй зохисгүй зарцуулсан НДЕГ-ын холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах.
2. Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 4.2.1²⁵-т заасан хуулийн хамрах хүрээнд Шүүхийн байгууллага хамаарч байхад салбар хуулиар тэтгэвэр тогтоох насыг тусад нь хуульчилсан байгаа нь ерөнхий хуулийн зүйл заалтыг үгүйсгэсэн байх тул салбарын хуулинд тэтгэвэр тогтоох насыг тогтоох нь зүйтэй эсэх талаар санал уламжилж өгөх.
3. Орон нутгийн НДХ-ээс боловсруулан хүргүүлсэн төсвийн төслийг өмнөх оны гүйцэтгэл болон бусад суурь мэдээлэлд үндэслэн санхүүжилтийг шаардлагатай санд нь хуваарилахаар батлах талаар НДЕГ-т уламжлах.
4. ЭМДҮЗ-ийн 2017 оны 03 дугаар тогтоолын II хавсралтаар батлагдсан Эрүүл мэндийн даатгалын байгууллагын дүрэмд заасны дагуу ЭМДЕГ, ЭМДТ-ийг ЭМД-ын хууль тогтоомжийг олон нийтэд сурталчилах, таниулах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмжийг ЭМДЕГ-т хүргүүлэх.
5. Эмийн сангуудтай хийсэн даатгуулагчдад эмийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээг дүгнэсэн үнэлгээ, үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөл, эмийн хангалт зэрэг нөхцлүүдийг харгалзан эрүүл мэндийн байгууллагуудад санхүүжилтийг оновчтой хуваарилж, батлах талаар зөвлөмжийг ЭМДЕГ-т хүргүүлэх.

АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА Л.ШАГДАРСҮРЭН ТАНАА

1. Төвлөрсөн харилцах дансанд төвлөрч байгаа шимтгэлийн орлогыг хуулинд заасан хувь хэмжээг үндэслэн санхүүжилтийг тухай бүр тооцож, хуваарилж байх.
2. Нас барсны дараа сарын тэтгэврийг бүрэн олгох, шинээр тогтоосон тэтгэврийн хувийн хэргийг дахин хянаж бүрдлийг хангаж, Төрийн аудитын газарт хариу ирүүлэх.

²⁵ /өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

3. ХЧТА-ны тэтгэмж олголтод хяналтыг хэрэгжүүлэхдээ эмнэлгийн бүртгэлийн цахим системтэй, ажил олгогчийн тодорхойлсон ажилласан жилийг НДШ төлөлтийн програмтай тулган баталгаажуулж олгох.
4. НДС-аас тэтгэвэр, тэтгэмж авагч иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар сургалт, сурталчилгаа явуулах. .
5. Даатгуулагчид олгох тэтгэмжийг аж ахуйн нэгж, байгууллагын НДШ-ийн өглөгт суутган тооцдог байдлыг таслан зогсоох.
6. Ажилгүйдлийн тэтгэмж авсан хугацаанд ажилд эргэн орсон даатгуулагчид олгосон тэтгэмжийг санд буцаан төлүүлэх арга хэмжээ авч хариу ирүүлэх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/29

Дорноговь аймаг, Сайншанд сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйлийн 15.1.12, 15.2.2, 19 дүгээр зүйлийн 19.3.3, Ерөнхий аудиторов 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан Гүйцэтгэлийн аудитын журмын 12.40 дэх заалт, мөн оны А/95 тушаалаар батлагдсан ТАБ-ын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам, 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамж, аймгийн Аудитын газрын 2019 оны бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөөний дагуу "Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлан, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Албан шаардлагын хэрэгжилтийг хангуулах, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, үр дүнг 2020 оны 02 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг аймгийн НДХ-ийн даргад зөвлөсүгэй.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн даатгалын тасагт хүргүүлсүгэй.

4. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Энхцэцэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР





Ч.АРИУНАА


НИЙЦЛИЙН АУДИТЫН БАГ

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД:

ГҮЙЦЭТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР		Э.ЭНХЦЭЦЭГ
АУДИТОР		Б.УРАНБИЛЭГ
ГЭРЭЭТ АЖИЛТАН		Д.ДЭЛГЭРЗУЛ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Ч.АРИУНАА
-----------------------------	--	-----------



АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.